

The background of the cover is a warm, golden sunset over a landscape. In the foreground, several gold bars are scattered on a dark surface. One bar in the lower right is clearly visible, with the word "GOLD" and the purity "999.9" stamped on it, along with the date "200900" and a serial number "22017".

**Ш.ДУЛМАА**

**АЛТАНД ДАРАГДСАН  
АМЬ  
/ТУУЖ/**

**Улаанбаатар хот  
2006 он**

Алтанд дарагдсан амь  
Зохиолч: Ш.Дулмаа

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

## Өмнөх үг

Энэ тууж нь өнөөгийн манай амьдралд болж байгаа уйл явдлаас сэдэвлэн бичсэн, хүмүүсийн амьдралыг үзэх үзэл, ороо бусгаа цагийн салхинд туугдаж яваа зарим хүний булчимгуй зан авир, амьдралыг мөнгөтэй л бол сайхан байх юм шиг бодож явдаг зан суртахууны хоцрогдол, амь насаа золиослож алтны төлөө үхэлдэн цэл залуугаараа хорвоог орхиж байгаа үнэн бодит уйл явдлыг энэ туужид өгүүлэхийг хичээв.

Бас алт гэдэг аминд халтай гэж хуучуулын ярьдаг үнэн үг болохыг манай залуус ойлгож ухамсарлаж энэ хэцүү хүнд бартаатай зам руу битгий хальтраасай гэж энэ туужийг бичлээ.

Эрхэм мэргэн уншигч та бүхэн өөрийн оюундаа тунгааж болгоох буй за.

Зохиогч

## Алтанд дарагдсан амь

(Тууж)

Их хотын дүүрэг бүхэн хөл хөдөлгөөн ихтэй, зарим хүмүүс Засгийн газар унасан гэнэ. Одоо бүх хүн амь амиа бодох цаг болсон гэж үнэн худал нь мэдэгдэхгүй цуу яриа хүнээс хүнд, айлаас айлд дамжин хоромхон зуур тарж байв.

Ганиймаа, Цэнгэл хоёр хоёулаа дээд мэргэжилтэй хоёр хүүхэдтэй баян ч үгүй хоосон ч үгүй, нэг нь уул уурхайн инженер, нөгөө нь санхүүгийн мэргэжилтэн бүсгүй. Тэр хоёрын ажиллаж байсан байгууллага нь тарж, цомхотголын их салхинд туугдаж нэг хэсэг хоёулаа гахай үүрч, газар дэлхийгээр хэсэж Эрээн ч нэг орж явж, Орос руу ч баахан явж тэгээд бүр сүүлдээ нөхөр Цэнгэл нь залхаж нэгэн жижиг зоогийн газрын менежер болж мах ногоо нийлүүлж амьдралаа залгуулж байжээ. Харин Ганиймаа нь угаас жаахан гоёж гоодох дуртай, эдийн сонирхол ихтэй, бас чиг жаахан сээтэгнүүр зантай учраас гахай үүрэх ажлаа ер орхих дургүйгээс болж тэр хоёр жаахан хоорондоо тар тур хийж, заримдаа бүр салахдаа хүртэл муудалцах нь олонтой болжээ.

Цэнгэл энэ ороо бусгаа цагт чи бид хоёр шиг наймааны ухаан муутай улс төрийн байгууллагад л ажиллахаас өөр аргагүй байхдаа гэж хэлтэл харин Ганиймаа нь ширэв татан

-Үгүй ээ ерөө төрийн байгууллагад ажиллаад чи бид хоёр идэх хоолтой, өмсөх хувцастай явах юм гэнэ дээ, гайгүй ч байлгүй дээ.

Би ч жаахан наймаанд гүйж байгаад л амьдралаа дээшлүүлэхийг бодноо. Чи яахаа өөрөө л мэднэ биз. Харин хоёр муу хүүхдээ л хүний дайтай хүн болгохоо мартав даа. Чиний энэ арчаагүй шударга зангаас болоод манайх гэдэг айл ер нь сөнөх гээд байна шүү дээ. Мэдэж байна уу? Миний “шахаж” ирсэн бараагаар л нэг юм арай чуу амилж байгаа биз дээ. Чиний авч байгаа цалин гэж юу байсан юм. Нэг л сайхан нэр зүүсэн амьтан яваад байдаг. Энэ гэр орон, эхнэр хүүхдийнхээ төлөө чи ер нь юу хийж байгаа юм. Арчаагүй амьтан гээд л Ганиймаа уурлана. Цэнгэл:

-За яахав дээ тэгээд болох л байлгүй дээ гэхэд, Ганиймаа :

-Үгүй ерөө, болох л байлгүй гэсээр бараг жил боллоо. Чиний хийсэн юм гэж юу байна. Гөлийсөн хар новш минь. Ядаж нэг унах унаатай ч болохыг бодохгүй явган гүйгээд тэгээд болох л байлгүй гээд сууж байдаг. Дүүрсэн муу амьтан гэж үглэн улиглана. Тэгээд Ганиймаа Эрээн орно гэж яваад дөрөв хоноод ирдэг байсан бол заримдаа бүр долоо, арав ч хонож ирдэг болж худалдаа наймаанаас өөр бодох ч юмгүй нэгэн болсон нь тэр хоёрын амьдрал нэг л биш болж байгаагийн шинж гэмээр ажээ. Үнэндээ Зах зээлийн нийгмээс өмнө тэднийх эвтэй, найртай сайхан айл байж. Харин сүүлийн хоёр жил авгай нь наймааны ухаанд боловсорч мөнгөний “өвчин” туссанаас болоод тэр хоёрын харилцаа нэг л хөндий хүйтэн болж юм л бол эхнэр нь мөнгө, мөнгө гэж хашгирсаар байгаад Цэнгэлийн сэтгэлд нэг л таагүй уур амьсгал сэмхэн шургажээ. Гэлээ ч Цэнгэл өөрийн гэр орон амьдралаа аль болох өөд татах гэж, гэгээн өдөр сэтгэлээ шаналгаж, гэрэлгүй шөнө зүүдэндээ зовнил тээж яваа нэгэн билээ.

Ганиймаа нэг удаа Эрээн орохдоо нэгэн сэргэлэн “чөтгөртэй” тааралдаж тэр нь хайр амлан шөнийн турш загас наадуулан жаргажээ. Тэр цагаас хойш нөгөө муу нөхөр нь юу ч биш санагдаж бэлэн амалсан түүний үгэнд орж хорвоод үзээгүй юмаа үзэх нь тэрээ.....

Шөнийн харанхуй орчлонг бурхсэн нам гүмд галт тэрэгний тур тар хийх чимээнээс өөр юу ч эс сонсдох намуун агшинд нэгэн купенд Ганиймаанөгөө залуутайгаа хоёулаахнаа жижиг гэрлийн өмнүүр цэнхэр алчуур татаад хөх туяан дунд нүв нүцгэн, “түүний найз залууг Заяат гэдэг”, тэр бас нүцгэн хоёулаа үнсэлцэн тэврэлдэн загас наадуулан, Би чамд хайртай, Би ч бас чамдаа хайртай. Чи миний сэтгэлийн од, чи миний хайрын ганц нар гээд л озон үнсэлцэж орчлон ертөнцийг мартан урт шөнийг баран, уг хэлээ эвдэн эрхэлж, үлгэн үлгэн үнсэлцэж хоёулаа сайхан амьдарнаа. Хэзээ ч салахгүй. Бид хоёрын сэтгэлийг хэн ч холдуулж дийлэхгүй гээд ёстой нэг нялуурахын дээдээр нялуурч, авгай нөхөр хоёр шиг л явжээ. Үүнээс хэдэн хоногийн дараа Ганиймаа урдаас ирэхдээ хоёр хүүхэддээ хувцас, чихэр жимс авчирсан боловч нөхөртөө юу ч гялайлгасангүй. Тэр бараг дугарах ч дургүй жишуу харж суугаад нэг л хачин байв. Орой болж унтах болоход Ганиймаа:

-Чи диван дээр унт! Би ядарч байна гээд ганцаараа хэвтээд өгөв. Шөнө Цэнгэл нэлээд хэдэн хоног эхнэр нь эзгүй байсан бас ч гүй Ганиймааг санаж мөрөөдөж, хүлээсэн болохоор түүн рүү очоод өвөрт нь орох гэтэл цаашаа бай! Би чамтай унтмааргүй байна гэжээ. Цэнгэлийн дотор жаахан эвгүй юм бодогдоод яахлаараа нөхөртэйгөө унтах дургүй болчихдог юм бэ. Энэ чинь л харин сонин байна гэхэд Ганиймаа сонирхоод байх юу байхав. Би ядраад байна. Унтах минь гээд хөнжлөө угз татав. Цэнгэлийн зэвүү нь хүрч чи урд нь явж ирээд зугээр л байдагсан. Энэ удаа яахаараа тэгтлээ ядарчихдаг байнаа гэхэд яасан ч байж болно шүү дээ. Энэ ардчилалын үед бүсгүйчуудийг дургүй байхад нь оролдоод байвал дарамталсан болдог гээ биз дээ. Би одоо чиний дарамтанд баймааргүй, жаахан чөлөөтэй баймаар.

Хүнд чинь эрх чөлөө гэж нэг юм байна биз дээ гэхэд Цэнгэл эхнэрийнхээ өвөрт ороход дарамталсан болдог юм бол энэ олон гэр булүүд яаж шүү амьдрах болж байна. Ер нь чиний ааш зан чинь нэг л биш болоод байх юм. Миний өвгөн юутай л учраад байна даа. Элдэв дэмий хүний үгэнд орж сэтгэл санаагаа хувиргаад байгаа юм биш биз дээ гэхэд Ганиймаа:

-Үгүй муу тэнэг минь чи одоо бас хардаж байгаа хэрэг үү гэж учир зүггүй уурлаад тэгэж ч чамд доромжлуулахгүй шүү. Хүнд чинь жаахан ч гэсэн сэтгэлийн юм байдаг байгаа даа. Чамд ямар тийм юм байх биш дээ. Ер нь би чамтай ингэж зууралдаж байх сонирхол ч алга. Чиний энэ балай гуйлгачин амьдралаар чинь хэдий болтол амьдрах юм. Чи ойр хавийн айлуудаа хар. Ганаагийнхыг, Цогоогийнхыг, Ээркаагийнхыг цөм л унах унаатай, өмсөх чамин хувцастай, гэр орон нь гэж бурхны лавиран гэдэг шиг л сайхан айлууд байна. Тэгэхэд чи бид хоёр л гэж хоёр муу өрөөндөө гэвтнөөд л хөл дүүжлэх унаа ч үгүй, хүнд тавиад өгөх олигтой тавгийн идээ ч үгүй л сууж байна шүү дээ. Ийм амьдрал гэж байдаг юм уу... Цэнгэл:

-Гайгүй байлгүй дээ. Бид ч гэсэн иймэрхүү болж болно шүү дээ. Харин хичээл зүтгэлхэн хэний маань ухаан чадал л мэдэх хэрэг. Чи юундаа бухимдаад байгаа юм бэ. Нэг л өдөр бүх юм бий болчих гэж байхгүй шүү дээ гэхэд чамайг харсаар байвал миний богинохон амьдрал гүйцэхгүй байлгүй гэж өгүүлэв. Ингээд Цэнгэл эхнэрийнхээ бэлхүүсээр нь тэврэх гэтэл их л зэвүүн болиоч! Би чамтай унтмааргүй байна гэж хэлээ биз дээ гэж ширүүнээр өгүүлэн түүний гарыг зайлуулав.....

Өглөөний наран цонхоор тусаж өрөө тасалгаа нь гэрлээр гийсэн байхад Ганиймаа гэнэт сэрж ийш тийш харан босч хүүхдийнхээ өрөөг хараад тэд цөм алга. Цэнгэлийн орлуу харсан чинь цэмцийтэл хураагаад явчихсан байв. Ганиймаа:

-Ашгүй Цэнгэл ажилдаа явчихаж. Заяаттайгаа нэг яриадхая гээд утсаа шүүрэн залгалаа. За сайн уу? Би байна. Миний хонгор сайн уу? гэж цаанаас нь их л нялуун маягаар яриа эхлэв. Ганиймаа:

-Хүүш миний хайраа нэг сонин наймаа би сонслоо. Алтны уурхайнуудад шороог нь түүж алт олзворлодог нэг сайн арга бий гэнээ. Хоёулаа тийшээ явж түүнийг нэг сайн хараад ирье. Би урагшаа явна гээд Цэнгэлд хэлчихнэ. Чи нөгөө муу тэргээ асаагаад бензин хийгээд гараад ир!. Явах замдаа сайн ярилцая. Бас тэгээд хоёулхнаа явах юм чинь жаргах газраа жаргаад, саатах газраа саатаад л явна биз. Би идэх уух юмаа бэлдчихэе. За юу

-За заа 12 гэхэд л гарна шүү ..... Ганиймаа Цэнгэл рүү угасдаад би одоо урагшаа дахиад гарлаа. Хоёр гахай юм бөөндчихсэн. Одоо эргээд явлаа. Наад хоёр хүүхдээ сайн харж байгаарай. Би дөрөв хоноод л ирнэ гэж эелдэгхэн хэлэхэд тэр за ашгүй дээ. Манай хүний ааш нь засарчихаж. Хөөрхий! Үнэхээр ядарсан байхад нь би уурыг ньхургэсэн байна шүү дээ гэсэн юм бодоод л үлджээ. Ганиймаа, Заяат хоёр хөөрөлдөн Заамарын зүг машинтайгаа хурдлан хорин хоёрын товчоо өнгөрөөд нэг жаахан судаг руу замаас гажин гарч зогсоод машиныхаа суудлыг буулган янаглаж загас наадуулаад бие биенээн байн байн үнсэн үлгэж замдаа гарлаа. Би жаргал гэдгийг ч чамаас л амсаж байна гэж Заяатыг хэлэхэд Ганиймаа би ч гэсэндээ ийм хайр байдгийг мэдэлгүй л өдий хүрч дээ. Өрөвдөлтөй байгаа биз. Үнэндээ би чамтай учраагүй бол нөгөө муу мангартайгаа “нөхрөө” хэлж байна, үйлээ үзэж амьд үхсэний хооронд л байдгаараа байж л байх байсандаа. Хоёулаа эндээс ихээхэн алт олж болох боломж байвал үзээд алддаг хэргээ гэж Заяат их үнэмшилтэй нь аргагүй хэлнэ. Ганиймаа тэгэлгүй яахав. Айл шиг сайхан айл болчихсон хоёулаа жаргал гэдгийг нэг амсаад сууж байвал болоо.

Харин энэ улсууд өөрсдөө л ухаж алтыг авдаг гэх юм. Тэр газар шороо ухна гэдэг л надад харин хэцүү санагдаад байгаа юм. Хүнээр ухуулахаар хамаг том алтыг нь авчихдаг гэлцэх юм. Явал дээр юм болдоо. Чи юу гэж бодож байна.

Өө тэр яахав. Алт нь олдож л байвал ухаж авах яах вэ? Үзээд л алдая. Хүн хийж чадаж байгаа ажлыг чинь би хийх л байх гэж бодож байна. Ганиймаа харин тийм нь тийм л юм гэхдээ би чамаар газар шороо ухуулмааргүй л байна гэхэд Заяат за тэр яах вэ? Хоёулаа байдлыг харъя. Ямаршуухан янзтай ажил юм, олон айл л эндээс амьжиргаагаа залгуулдаг гэх юм байна. Үнэхээр орлого сайтай юм бол үзээд алддаг хэргээ гэж нэлээд итгэлтэй өгүүлэв. Ийн ярилцсаар явтал оройн наран шингэх дөхөж уулсын цаана улбар туяа тусаж энхийн сайхан үдэш монголын тал нутаг үнэхээр жаргалын орон гэмээр, сэнгэнэсэн сайхан агаараар үлээж сэтгэл зүрхийг ариулж янаг хоёрын явах замыг улам ч хөөр баяртай болгож байв.

Уурхай дэрлэн буусан олон гэрийн дундуур гудамжлан гарсан замаар тэр хоёр юу хүүгүй орж ирлээ. Одоо хайшаа явах вэ? гэхэд Ганиймаа тэр хойт гудамж руу эргээд Батаагийнх байдаг юм. Тэнд л очье. Эртүүд Батаагийн авгай Цэцгээ манайд очоод Заамар орвол очоорой гээд явсан юм. Тэр бид хоёр арван жилийн нэг ангийнх байхгүй юу. Сайхан айл байдаг юм хоёулаа тийшээ очье. Хашаанд нь машинаа тавиад бүр амар шүү дээ. Ганиймаагийн зааснаар Заяат

Тэр хашааны үүдэнд хүрч зогслоо

...Өглөөн нарны алтан цацраг доогуур Ганиймаа, Заяат, Цэцгээ гурав уурхайн ухсан хуучин шороон орд руу агшнаа давхин хүрэв. Энд тэндгүй хүмүүс газар хонхойлон ухаж бас шигшүүр барьсан хүмүүс элс шуудайлж, шигшүүр нь үүрч, дүүрэх нь дүүрч их ажлын талбар мэт алтны хулгайн ажил өрнөж байх нь нэн сонин агаад энэ олон хүнд тэр алт эрдэнэ яаж шуу олдож яаж хүн бүр өдрийн олзоо ууталж авдгийг тааж мэдэхэд бэрх амой.

Цэцгээ хэзээний өөрийн гэсэн ухдаг газартай тэндээ бас олон найз нөхөдтэй болчихсон болохоор тэдэнтэйгээ баяр хөөртэй мэндэлж, ердөө л шууд ажилдаа орлоо. Эрин зууны их хүч чадал агуулсан аварга том экскаваторын өм цөм ухаад хаясан газраар шороо малтаж алт олно гэхэд бараг үлгэрийн юм шиг санагдах агаад тэнд байгаа хүмүүсийг ажихад эртний боолчуудын хөдөлмөр санаанд орно. Удалгүй Цэцгээгийн нөхөр Бат ирж том хүрзээр газар өмлөн ухаж бөөн бөөн шороо уутлав. Заяат ч эр хүн болохоор Батаад туслан бас хэдэн хүрз шороо онгилж хөлсөө гартал ухаж үзэв. Тэгээд энэ уул нь хэцүү боловч сонирхолтой ажил байна. Чи ч бүр дадамгай болжээ гэж Батаад хэлэхэд дадаж ядаад байх юмгүй. Энэ баян газар дэлхийгээс бид авч л чадах хэрэгтэй. Та хоёр үнэхээр сонирхож байгаа бол энэ хэсэг газрыг ухаад л үз. Авсан шороогоо орой шигшээд хар. Дэлхийн юмыг та хоёроос бид харамлаад яах вэ? Зарим нь бүр ухаж байгаа газартаа хүн ойртуулахгүй шүү дээ. Энэ дээр чинь нэг ёсны дайн болдог юм. Бид хоёр бол тэгэж харамлаад байдаггүй. Дэлхийн хишиг, эх орны минь баялаг гээд л өөрсдөө чадах чинээгээрээ л авдаг. Зарим өдөр гурав дөрвөн пеницилийн шил алт авчихдаг, заримдаа бур ганцханыг арай чүү олдог. Гэхдээ хүчээ гаргаж хөлсөө дусааж олж байгаа юм болохоор дажгүй л байдаг. Олсон алтаа энэ маань долоо хоногтоо нэг удаа зах дээр аваачиж борлуулдаг. Алт авдаг ченжүүд тэнд аяндаа зөндөө байдаг. Та хоёр зоригловол яахав хэд хоног үзээд л алд. Бид хоёр заагаад өгье. Амьдрахын төлөө л зүтгэж байгаа болохоор бид ялгаа юу байхав гэж Батаа их л чин сэтгэлээсээ өгүүлэв....

Бурэнхий болох үеэр тэд хэдэн таар шуудай элс шороотой хашаандаа хүрч ирлээ. Том охин нь хоол хийчихсэн тэднийг хүлээж байлаа. Хоол цайгаа идэж уусны дараа тэд нэг жижиг модон амбаарт орж усан утгуурт элсээ хийн хэдэнтээ хөдөлгөн шүүрэн шигшүүрт шүүхэд яах аргагүй алтны үртэс гяптаганан гялалзан бөөгнөрч үлдэх нь нэн сонин. Тэгээд шүүн тунгаасан үртсээ тусгай тавиур дээр хатааж пеницилийнхээ шилэнд савлахад тэр өдрийн авсан шорооноос дөрвөн шил алт гарав. Нэг шилийг нь арван мянгаар өгнө гэвэл дөчин мянган төгрөгний ажил өдөртөө хийсэн байх нь. Заяатын бодолд их л унацтай мэт санагдаж, өдөрт дөчин мянга, долоо хоногт 280 мянга, сард 1 сая 120 мянга болно гэвэл жилд бүр гуч гаруй саяын ч орлого олж болох юм байна гээд дотроо их л баяртай байв. Маргааш нь Ганиймаа, Заяат хоёр хүрз шуудай бэлдэж, жаал идэх юм аваад Батааг дагаж уг газар дээр ирээд гэрийн буйрын чинээ газар заалгаж аваад ухаж гарав. Ганиймаа угаас хүнд хүчир ажил хийж үзээгүй учир Цэцгээгийн нэг хөвөнтэй хуучин дээл өмсөөд ирсэн чинь хөлөөр нь ороолдоод ер хөдлөх янзгүй шороон дунд нүд нь харагдах төдий амьтан арай ядан зогсож байв. Харин Заяат тун шавдангуй ажиллаж бас зарим нэг бөөн шороог ухаж гаргаад шигшүүрдэн алтны чулуутай хэсгийг нь түүж уутлана. Тэгэж байтал гэнэтхэн нэг цагаан чулууны хажуугаас гялтганасан шар юм харагдах нь тэр. Хичээнгүйлэн ухаж гаргавал хэсэг бөөн алт “саморотка” эрхий хуруун чинээ томоор олдох нь тэр. Барагцаагаар тав зургаан цэн аягүй бол лан алт ч байж магадгүй их алт олов. Баярлаад нөгөөхөө Ганиймаад үзүүлж, бас

Батаа, Цэцгээ хоёрт харуулсан чинь Батаа эр хүн чи азтай л байна гэхэд Цэцгээ

-Үгүй ээ чи манай газрын талаас л олсон юм чинь хуваалцана биз дээ гэхэд Заяат харин ээ уул нь ч хуваалцмаар л байна. Даанч азны юм болохоор та хоёртой хуваалцмааргүй байна. Дараа дахиад олдвол талыг нь үг дуугүй өгнөө гэхэд Цэцгээ хцс яасан ч хуншгүй юм билээ гэхэд Батаа:

-Заяатын зөв өө. Эр хүн чинь азтай олдсон олзоо эхлээд өөрөө авалгүй яахав. Чи бид хоёр өдий жил ухаад ийм юмтай таараагүй шүүдээ. Тэгэхээр хүний аз тавилан гэж нэг юм байдаг шиг байгаа юм. Чи үүнийг булаацалдаад хэрэггүй. Ер нь “Олзны бага нь дээр” гэдэг биз дээ. Чи бид хоёр бишгүйдээ л хүртсэн. Илүү шунахын хэрэггүй шүү дээ. Харин өнөө орой эртхэн харьж олзоо тэмдэглэж угаанаа гэхэд Цэцгээ дурамжхан өөрөө олоогүй байж чи бид хоёр угаагаад байхдаа яадаг юм гэхэд Батаа:

-Энэ чинь чи бид хоёрын сонгож авсан газраас гарсан юм болохоор дэлхий хишгээ хайрлаж байна гэсэн үг. Угаанаа, угаалгүй яахав. Ер нь Цэцгээ чи жаахан ухаантай байлдаа. Дэлхийн хишгийг хүнээс харамлаж болдоггүй юм. Аль хэрийн өглөг өгөхөө бурхан мэдэж байгаа, олдосноо л дуугүй хүртэж байя гэж тайван өгүүлэв.Тэгээд дөнгөж нар жаргамагц Батаа, Цэцгээ хоёр хамаг юмаа жин тан боогоод одоо харьцгаая гэхэд нь Заяат бүр гайхаж

-Ийм эрт буух гэж үү гэхэд Батаа

-Тийм ээ өнөөдөр онцгой өдөр байна. Эртхэн бууцгаая. Цаана нь ажил байна гэхэд Ганиймаа, Заяат хоёр хэдий дуугай байсан ч арга буюу тэр хоёрын аяыг дагаж юмаа хумиж аваад хөдлөв. Ирэх замдаа Батаа нэг дэлгүүрийн гадаа бууж үлдэв. Нөгөө гурав гэртээ ирж хоол цайгаа идэх гэж байтал Батаа гаднаас тор дүүрэн юм барьж ирээд

-За хө одоо Заяатынхаа олзыг угаанаа. Дэлхийн хишиг гэдэг тэгэж хэн хүнд амархан олддог эд биш шүү. Та хоёр ч азтай улс юмаа. Хангай дэлхийдээ сүү өргө. Ганиймаа чи гар! гэж шанаганд сүү хийгээд түүнд өгөв. Заяат мэл гайхаж яасан ч сүртэй юм бэ дээ жаахан алт олсны төлөө гэж дотроо дурамжхан бодоод,

-Бид хоёрыг согтоож унагаад энэ олсон жаахныг маань авах гэж байгаа юм биш байгаа гэж муу санаалан өнөөдөр би уухгүй юм шүү. Согтож болохгүй гэж өөртөө тушаагаад бодол болон сууж байв. Гэтэл Батаа яах ийхийн зуургүй ширээ засаад чихэр жимс тавьж бөхөл мах чанан сайхан хоол хийж баярын ширээ бэлэн болов. Ганиймаа Заяатын балгадгийг мэдэх учраас өнөөх маань согтохлоороо олон үгтэй дээ. Элдэв юм донгосоод хүний дургүй хургэчих бий гэж их болгоомжлон суув. Батаа үнэн сэтгэлээсээ баярлан

-За та хоёртоо баяр хургэе. Байгалийн их өгөөж хишгийг ганцхан өдөр ажиллаад хүртлээ шүү дээ. Үүн шиг баяр гэж хаа байх вэ? Та хоёрынхоо цаашдын их олз омог, ажлын амжилтын төлөө ууцгаая. Бүгдээрээ хүндага өргөн уухад Заяат дөнгөж амсаад тавьлаа. Батаа, Заяатыг хүүе Заяат чи яагаад тавиад байна. Энэ хүүхнүүдтэй хоёулаа барьцахгүй шүү, эр улс байна. Давай, Поехали гэж хөгжилтэйгээр хэлээд хундгаа өргөхөд Заяат за би ч өнөөдөр бие жаахан тааруу байна. Яахав эхний хундгыг л нэг тогтооё гээд уув. Дараа нь мах, ногоон хачир зэргийг амтархан идэцгээв.



Тэгээд халуун яриа өрнөж ер энэ маягаар ажиллаад байвал жил болоход л юм юмтай болно доо. Бид хоёр гуравдах жилдээ л ажиллаж байна. Айлаас дутахааргүй л болоод байна. Заримдаа алт хулгайгаар ашиглалаа гээд цагдаа нар торгож л байдаг юм. Тэгээд хүмүүс авч л байдаг юм. Баян дэлхий өгөөжөө хайрлаад л байдаг юм даа. Харин залбирч л хүртэх хэрэгтэй гэхэд Ганиймаа харин тийм шүү. Би ч та хоёртоо их л баярлаж байна. Амьдралын минь нурж яваа үед ингэж тусалж байгаад тун их баярлалаа. Та хоёртоо их амжилт ерөөгөөд энэхүндгаа тогтооё гээд Заяат руу харсан чинь дөнгөж амсаад л тавих нь тэр. Энэ маань яагаа юм бол, уул нь уухайн тас л хүртэж баймаар юм. Нэг л дүнсгэр байх чинь, энэ хоёрыг гомдоочих бий дээ гэж дотроо бодоод манай өвгөн өнөөдөр ажилпасандаа бие нь няцраад нэг л ядруухан байна. Уул нь ийм хүн биш л дээ. Энэ рашааныг чинь сайхан хүртэж орхидог л юмсан даа. За яахав. Оронд нь би л барихаас гээд хүндгаа өргөв. Батаа, Цэцгээ хоёр ч хөөр баяртай ууцгаав. Тэгээд ууж идэцгээсний дараа тус, тусын шороогоо шигшиж ажилдаа орж шөнө дөл болтол сууцгаав. Заяат Ганиймаа хоёр тэр өдөр гурван пенцилиний шил алт, бас тэр их цул алт олсондоо урамшиж их л сэтгэл хангалуун унтахаар хэвглээ. Ганиймаа Заяатыг үнсэн таалж Сүйд болохын зэрэгцээ

-Чи өнөөдөр яагаад уусангүй вэ? гэхэд Заяат нөгөө дотор санаагаа хэлэлгүй,

-бие жаахан муу байлаа. Үнэндээ шороо ухах чинь тийм ч амар ажип биш байна шүү. Харин чинийхээ төлөө, сайхан амьдралын төлөө гэж би ийм юманд өөрийгөө аймшиггүйгээр шийтгэж байна шүү дээгэхэд Ганиймаа тэгвэл чи энд ажиллах дургүй байгаа юм шив дээ гэхэд, дургүй нь юу байхав дээ. Ер нь хүндхэн л ажил байна. Харин зун нь эндээ ажиллаад өвөл нь наймаанд гүйгээд байвал ч амьдрал ондоо болох нь ч болох л янзтай шүү. Тийм шүүдээ. Чамайг би итгэж л байгаа шүү. Заяат, тэгэлгүй яах вэ? Чи надад итгэхгүй бол өөр хэн итгэх билээ дээ. Миний хонгор. Би үнэндээ чиний төлөө хийх л бүхнийг хийнээ. Миний ангир битгий зов! Чи бид хоёрт юм бүхэн бий болно. Жаргал цэнгэл, эд агуурс, алт мөнгө цөм л байх болно тээд Ганиймаагийн ангир цээжинд хошуугаа хийж нэгэн агшинд орчлонг умартав. Тэгээд тэр хоёр гүн нойронд дарагдан унтав.

Маргааш нь хэзээ язааны хуучин ажилчин шиг хүрз шуудай, шигшүүрээ аван тэр хоёр Батаа, Цэцгээ хоёрыг даган уурхайн шороо руу яаран алхлав. Ийн ажилласар дөрөвдөх өдрөө Ганиймаа шуудангаар хот руу явж Заяат нь тэндээ үлдэв. ГаниймааТүц-нээс ногоо, жимс, өндөг тэргүүтнийг худалдан авч торондоо хийгээд гэртээ ирлээ.

Хэн ч байсангүй. Цэнгэл рүү утасдаж хүүхдүүд хаачсан бэ? гэхэд

-аавынд байгаа гэсэн товчхон хариулт авч, чи хэдийд ирэх вэ? гэхэд Цэнгэл оройхон очноо. Өнөөдөр ажил ихтэй байгаа. Чи намайг хүлээсний хэрэггүй, хоолоо идээд амарч бай гэв. Ганиймаа Цэнгэл ямарч сэжиг авсангүй дээ. Алтнаас их ашиг гарвал Цэнгэлээс царай алдахгүй, өөрийн гэсэн гэр оронтой болно. Найман өрөө байшинтай болчихоод хоёр хүүхдээ ч авна. Амьдрал миний гарт байнаа. Заяат ч ёстой миний төлөө зүтгэх хүндээ. Хэзээ ч бэлэн гээд л гүрийгээд байх хүн байгаа юм. Үгүй мартсанаас Заяатыг найз нар нь яагаад бэлэн Заяат гэдэг юм болоо. Үүнийг нэг сонирхож мэдье байз. Ганиймаа толины өмнө жаахан эргэлдэж байснаа хэдэн хуруун шилтэй алтаа цүнхлэн нөгөө олдвороо ч нандигнан боогоод гарч явлаа. Зах дээр очоод пенцилиний шилтэй алт барьж яваа хүмүүсээс алт ямар үнэтэй вэ гэхэд арваннэгэн мянга жаахан татаад өгнөө гэж байв. Алтыг бөөнөөр авдаг газар байна уу?

Бий бий. Тэр хойно сууж байгаа бор дээлтэй хүний тэндээс л асуу. Шууд арваар бол дороо л авах байх..... Ганиймаа яаруухан алхалж тэр хүний дэргэд очоод

-Алт бөөндөж авах уу? гэвэл авна. Хэдий хэр юм байна? Хэдээр өгөх вэ? гээд нүд нь сэргээд явчихав. Жижиг Шилтэй арван нэг байна. Аа тийм үү. Цөмийг авъя. Нэг жижиг шилтэйг нь арван мянгаар авна даа гэж хэлэхэд Ганиймаа

-за та үзэх үүгэхэд тэгье хоёулаа тийшээ явъя гэж зүүн хашааны буланлуу заагаад тийш очиж Ганиймаагийн алтыг үзээд, өө чинийх чинь их нягт хийсэн юм байна. Нийт нь 120 мянгаар л авъя гээд Ганиймаа руу харахад тэр толгой дохив. Нөгөө хүн шууд мөнгөө тоолж өгчихөөд

-Өгсөн авсандаа өлзийтэй байх болтугай гээд эргэх гэтэл нь Ганиймаа

-Ахаа надад “самородок” байгаа авдаг газар байна уу? гэхэд алив үзье гээд түүнийг нь харчихаад энийг чинь улсын банканд өгсөн дээр дээ. Энэ чинь чухал олдвор шүү дээ. Улсынхаа санд өгсөн нь дээр дээ хүү минь. Тэнд ийм ховор юмыг өндөр үнээр авдаг гэж дуулсан юм байна. Хүү минь тийшээ л оч. Хувь хүнд өгөөд дэмий биз дээ гэв.

Ганиймаа нээрээ ч тийм дээ. Ийм ховор олдворыг хамаагүй дамьканд өгөөд яахав. Тэр улсын сан гэдэгт нь л яваандаа өгье. Харин үнэт зүйлс хадгалдаг газар хаана бий гэлээ дээ гээд түүнийг эрэхээр нэг машин барьж аваад шууд хотын банкны зүг явлаа.....

Амьдрал эрэгсээр... Өдөр хоног ээлжилсээр жил өнгөрчээ. Ганиймаач Заяаттайгаа уурхайн шороо ухсаар. Улам л шунал нь хөдөлсөөр. Хааяа нэг гэртээ үзэгдэх боловч Цэнгэлтэй бараг үгний зөрөөгүй шахам өдий хүрч тэр хоёрын сэтгэл ч бие биенээсээ хөндийрч эхэлжээ. Цэнгэлийн ажил зав чөлөөгүй болохоор хоёр хүүхдээ хааяа аавындаа явуулж, өнжүүлж, хонуулна. Тэртэй тэргүй эх нь хайхрахгүй болсон хүүхдүүд сүүлдээ ээжээ ч үгүйлэхгүй болж аавыгаа л гэх агаад аав нь ч хоёр хүүхдээ л гэж бүх анхаарлаа тавьж байдаг аж.

Ганиймаа ч уурхайн шорооноос ухсан алтаа сэм сэмхэн зарсаар л бүр сүүлдээ Батын хашааны дэргэд өвлийн байшинтай тов хийсэн нэг хашаа худалдаж аваад хоёулаа бараг тэндээ суурших аядаж хааяа хот ирэхдээ Ганиймаа Эрээнээс бараа татдаг янз үзүүлэхэд гурван төгрөг Цэнгэлд өгөх боловч Цэнгэл түүнд нь баярлах ч үгүй, түүгээр нь хоёр хүүхэддээ хувцас хунар, ном дэвтэр аваад л дуусна. Цэнгэл авгайгаа хүнтэй нөхцөж явааг мэдээгүй боловч зөн совингоороо энэ нэг биш гэж бодовч түүнтэй элдвийг ярьж суух цаг зав тун ховор. Шөнийн бор хоногт арай чүү гэрийн бараа харна. Авгай нь гэртээ байсан ч түүнтэй энгэр зөрүүлэх хүсэлгүй мэт санагдаж, өөрөө ч нэг их дурлахаа больсон болохоор тэр хоёрын хооронд бухэлдээ хүйтэн агаар амьсгал шургасан, нэг л холдохын цондон нүүрлэж байжээ....Тэгээд л нэг өдөр Ганиймаа ачааны машин авчраад л Цэнгэлийн эзгүй хойгуур ор диван, хөргөгч, зурагт бүх юмаа аваад

-Цэнгэлээ би бүр мөсөн явлаа. Дараа ирж хүүхдүүдээ авна. Миний хойноос битгий хөөцөлдөөрэй. Тэртээ тэргүй би чамд сэтгэлгүй болсон учир одоохондоо хоёр хүүхдээ бодоод байртай чинь үлдээлээ. Миний хойноос зовсны хэрэггүй. Би чам шиг арчаагүй амьтан биш. Амьдралын сайн сайхны төлөө тэмцэж, өөртөө таалагдсан ханиа ч сонгож авсан. Харин чи хоёр хүүхдээ л сайн харж байгаарай. Би хүүхдийн чинь өрөөнөөс юу ч аваагүй. Чи харин эр

хүн байна өөртөө унтах ор алив бүхнээ олж авах биз ээ. Би чиний хоцрогдсон үзэл бодол, нэгэн хэвийн амьдралд чинь байж чадахгүй болсон учир өөрийнхөө замыг бодлоо. Чамд сайн сайхныг хүсье. Ганиймаа гэсэн бичиг орхиод явжээ. Цэнгэл оройхон хэрд гэртээ орж ирвэл бүх юм нь ундуй сундуй болж хоосон өрөө угтахад хулгай орсон юм боловуу гэж сэжиглэж байтал ширээн дээр нэг зурвас тавьсан харагдав. Түүнийг уншаад дээрх өгүүлбэрүүд нүдний нь өмнө дурайж байх нь тэр. Ийнхуу нэгэн сайхан гэр бүл бутарч Цэнгэл үнсэнд хаягдсан шалз мэт нэн гашуудалтайгаар хоцорсон ажээ. Жил өнгөрсний дараа Цэнгэл нэг том компанийн босс болж, гурван том өрөө худалдан авч ээж, ааваа хоёр хүүхэдтэйгээ цөм нэг дор орж унах машинтай, эрх мэдэлтэй ч болжээ.

Ганиймааг явсны дараа эзгуй гэртээ долоо хоног өдөр шөнөгүй архидаж хорвоогийн гаслант амьдрал гэдэг энэ л юм байна хэмээн гунигаа дааж ядан байтал яамнаас утасдаад

-Чи төрийн өмчийн харьяалалд байдаг нэг том алтны уурхайн даргаар ажиллах боллоо. Нөгөөдөр хурлаар орно. Та бэлтгэлтэй байгаарай. Өнөөдөр дөрвөн цагаас даргатай ирж уулзах болсон шүү гэж яамнаас утасдав. Цэнгэл гэнэт сэхээ авч амьдрал минь бүр нурчихаад байхад ажил ингэж өрнөж байдаг. Үгүй ээ мөн хачин ч хорвоодоо. За яахав авгайд гологдсоноос биш ажилд гологдоогүй л яваа юм байна. Эр хүн долоо дордож найм сэхдэг гэсэн үг байдаг биз дээ. Үзээд л алдая хоёр муу хүүхдээ тэжээх л хэрэгтэй, хорондоо хүнээс доогуур орохгүй юм шүү гэсэн ухаарал, сэхээрлийн бодол толгойд нь эргэлдэж,

-ээж аавыгаа амьд байхад би муу явах эрх байхгүй. Хоёр хөгшин, хоёр хүүхдээ бодоод би хөл дээрээ босох учиртай. Энэ хорвоод ямар дахин төрөх гэж байх биш дээ. Хүн болж заяасных муу ээж ааваа ч зовоохгүй л амьдрах хэрэгтэй. Миний аав ээж хоёр намайг ямар сайхан өсгөж яаж уйлээ үзэж хүн болгосон бипээ. Би ингэж ч лойхгүй шуу. Ганиймаа орхиод явсан ч ганцхан олдох амьдралаа сүйтгэхгүй шүү. Энэ муу хар усыг ч уухгүй, урд нь ч би ямар нэг их уудаг байсан ч биш. Цэнгэлээ чи эр хүн юм бол хөл дээрээ бос! Аль хэдийн амь амиа боддог болсон энэ хатуу цаг үед чи толгой унжуулж суугаад юу хожих юм. Чи сэхээтэн хүн юм бол сэхээр! гэж өөртөө хэлээд угаалгын өрөө рүүгээ орж сахлаа хусаад, хувцсаа сольж дээд зэргээр гоёод яамруугаа гарч очлоо. Энэ өдрөөс хойш дөрвөн сар болоход Цэнгэлийн ажил ч жигдэрч яамнаас сайшаалын үг сонсдож, уурхайн их ажил өрнөдгөөрөө өрнөж, цалин ч өсөж, эрх мэдэл өндөржлөө. Нэг хүүхдээ тусгай сургуульд оруулж элитийн хүүхдүүдтэй цуг сургах боллоо. Тэгээд нэг орой гэртээ ирээд хоёр хүүхэдтэйгээ зурагт үзэж суутал охин нь

-Бид хоёр нэг сайн ээжтэй болмоор байна. Манай ээж биднийг нэгэнт орхиод явчихсан юм чинь, та ч ганцаараа уйтгартай, бид хоёр ч ээжгүй, ядаргаатай байна шүү дээ гэх нь тэр.

Цэнгэлийн бодож амжаагүй яваа юмыг охин нь пал хийтэл хэлсэнд гэнэт сэхээ авч, харин тийм ээ. Чиний хэлдэг зөвөө. Гэхдээ сайн ээж гэдэг л хэцүү дээ. Та хоёрын төрүүлсэн ээж чинь нэг л өдөр орхиод явчихсан. Тэгэхээр төрүүлээгүй, хаа хамаагүй хүн ээж чинь болно гэдэг тун амаргүй биз дээ. Тэгээд ч аав нь ээжээс чинь хойш энэ тухай ер бодоогүй юм байна. Дараа сайн бодож байгаад охиндоо хариу хэлье гэхэд охин нь

- Бодож ядаад байх юм юу байгаа юм. Та л үүнийг шийднэ шүүдээ. Танд л халамжтай сайн хүн байвал бид хоёр тэр эгчтэй чинь таарнаа. Өвөө, эмээ хоёр ч таныг ханьтай болсон нь дээр гээд байдаг юм. За юу! ааваа гэж бараг албаар тулгах шахан өгүүлэхэд: Цэнгэл

-За за аав нь бодноо гэж хэлээд гол руу нь нэг юм зурах шиг болж гэнэт Ганиймаа нь бодогдож,

-Даанч дээ Ганиймаа ингэж биднийгээ орхих гэж одоо энэ муу хоёр хүүхдээ тэгээд хүний царай харуулах болж байна уу? Яасан их үйл вэ? Яаж ийм том болсон хүүхдүүд хүнийг ээж гэж хүлээж авах юм бэ? Тэр бүр бүтэшгүй зүйл гэж бодоход зүрх нь давчдаж, сая л Ганиймаад голгүй гомдосноо ухаарав

Тэгээд нулимсаа дотроо нууж хүүтэйгээ шатар тоглохоор өрөв.....

...Шинэ жилийн үдэшлэг болж уурхайн захиргаа олон сайхан оддыг урьж, бас тусгай өрөөнд захиргааныхан нийлж, даргаа сайн сайхны төлөө гэж хундага өргөн тулгаж хүн бүрийн царайд баярын гэрэл гэгээ тусаж, бүжгийн танхим руу зарим нь орж бүжиглэн хөөр баяр болцгоож байлаа. Ихэнх залуучууд бүжиг хийхээр гарч одлоо. Гэтэл ширээнүүдийн зүүн урд талд үйлдвэрийн эмч гэх гуч орчим насны мисс баймаар сайхан бүсгүй гав ганцаар үлдэж ширээн дээрх цэцгээр оролдон суухыг Цэнгэл ажиглав. Орлогч дарга нь элдвийг хүүрнэн хундага дахин дахин өргөх боловч Цэнгэл уухыг урьдал болгосонгүй, нөгөө эмч бүсгүйг хулгай нүдээр харан, яагаад ингэтлээ уйтгарлан суудаг юм бол. Энэ сайхан хүүхэн. Бүжгэнд урьдаг ч юм билүү гэж бодон суутал тэдний нягтлан гэх аманцар бүсгүй ирж даргаа хоёулаа бүжиглэх үү гэж урилаа. Цэнгэл хэдий дургүй байсан ч өөрийн эрхгүй бүсгүй хүнийг хүндэтгэн босов.

Эргээд ширээндээ ирж суухад нөгөө эмч бас л суусаар. Дэргэд нь жижүүр хийдэг нэг авгай ирж суусан харагдав. Тэгээд гэнэт Цэнгэлийн дотор эмчийг урьж бүжиглэе байз. Энэ сайхан од ч миний мэтийн бойлхой юмыг авч хэлэлцэхгүй биз дээ. Гэхдээ ганц орой ч гэсэн эр хүний сэтгэлээр хандаад үзье гэж дотроо бодоод хөгжим дуугарахад босон очиж нөгөө эмч бүсгүйг урихад их л эелдэгхэн байдлаар босож бүжиглэв. Сэнгэнэсэн сайхан сүрчигний үнэр, өндөр зэгзгэр нуруу, тормон хар нүд, савхан цагаан хуруу энэ бүхэн нь энэрлийн бурхан дэргэд нь заларч ирсэн мэт нэг л ариун тансаг санагдаад сэтгэл нь хөдөлж ер бусын догдлол өөрийн эрхгүй бүх биеийг нь эзэмдэж, нэг мэдсэн чинь гар нүүр нь хапуу оргин ул мэдэг чичирхийлж байгааг мэдрэн улам ч биеэ барин сандрав. Нөгөө бүсгүй ч бас жаахан ичингүйрэн гайхавч тэвэрт нь байгаа гоолиг нуруу энгэрийг нь түлхэн товойх хөх зэрэг нь түүний сэрлийг сэдээн ойрдоо түүний сэтгэлд орж байгаагүй тачаал, хайрын хүсэл нь бадран их л дотнохон санагдаж өөрийн эрхгүй жингүүдэв. Хөгжим зогсоход суудал руу нь дөхүүлж өгөөд -Их баярлалаа гэж мэхийн өгүүлэхэд бүсгүй сайхан харцаараа дуниаран мишлээж танд баярлалаа гэж сэтгэл хангалуун царайгаар өгүүлэв. Тэгээд тэр орой хэд хэдэн бүжигт урьж Цэнгэл ойрдоо баясаагүйгээр баясаж, Ганиймаагийн дэргэд ч ёстой жинхэнэ дагина юмаа гэж дотроо бодон нөхөр нь хаана байдаг юм болдоо гэж гэнэт санаа алдав.

Үдэшлэгийн дараа орлогч нь

-даргаа та эмчийг гэрт нь дөхүүлж өгнө үү эднийх бүр Баянхошууны тэрлүү байдаг юм. Одоо их орой болчихлоо гэхэд Цэнгэл дотроо баярлаж тэгье тэгье гэж их уриалагханаар өгүүлэв.

Хэд хоногийн дараа Цэнгэлийн бага хүүхэд нь халуурч ээж нь түүн лүү утасдаад хүүхэд халуураад байнаа бушуу ир гэхэд яг тэр үед нь яамнаас хүн ирчихээд ямарч гарах нөхцөлгүй

байсан болохоор тэр нарийн бичигтээ ийн хэлжээ.

-Чи манай эмчийг аваад манайх руу миний машинаар яваад манай хүүхдийг үзүүлээд, эм авч өгөөд ирэхгүй юу. Би хурлаас гарч болохгүй байна. Түргэлж үзээрэй гэхэд нарийн бичиг нь

- за за даргаа гээд ухасхийн гарч эмч дээр очоод:

-За хоёулаа даргынх руу явах боллоо. Хүүхэд нь халуураад байна гэнээ. Тэгээд дарга таниар үзүүлээд эм авч өгөөд ир гэнээ гэхэд эмч их гайхаж,

-би хүүхдийн эмч биш шүү дээ. Тэгээд ч даргын хүүхэд юм бол бүр ч хэцүү шүү дээ. Яаж би очих юм. Чи районы эмчид нь очихгүй юу гэхэд та хүний зовлон мэдэхгүй юм. Тэр хүүхдийн ээж нь орхиод явчихсан тэгээд эмээ өвөөтэйгөө цугаар хамт байдаг юм. Даргад зав байхгүй болохоор яараад байна шүү дээ. Та очиж үзээд эм бичээд өгчих. Би яахав эмийг нь ойртуулаад өгчихнө гэхэд эмч чагнуураа аван босов.

Эмчийг хаалга цохин ороход буурал толгойтой толиотой хөгшин угтаж:

-За хүү минь энэ хүүхэд халуураад болдоггүй ээ. Эцэг нь гэж нэг ажлын хэнээ туссан хүн ирдэггүй ээ. Би бур айгаад сууж байна гэсээр угтав.

Хүүхдийн өрөө нь их л тохилог агаад хүүхдэд хэрэгтэй юм бүхэн л байв.

Хүү эмчийг харснаа - эмчээ би өнөөдөр жаахан даарчихсан юмаа гэв. Эмч чагнаж үзээд ханиад хүрчихжээ. Би эм бичиж өгье. Хоёр өдөр босолгүй хэвтээрэй. Эмээ сайн уух хэрэгтэй. За юу гээд эмийн жорыг нарийн бичигт өгөв. Эмгэн хүүхдүүд минь ийшээ ор, цай уу гээд сүйд болов. Их сайхан тохилог айл байхыг ажиглаад ийм сайхан гэрээс үр хүүхдээ орхиод явчихдаг ямар хачин хүн байдаг байнаа гэж эмч дотроо бодоод тэднийхээс гарч одлоо.

Хэд хоногийн дараа нарийн бичиг

- дарга таныг дуудаж байна гэв.

Эмчийг Нараа гэдэг. Нараа юу болсон юм бол гэж нэлээд айсаар Цэнгэл даргын өрөөнд орлоо. Дарга хөгжилтэйгээр инээмсэглэн угтаж,

-Эмчээ баярласан шүү. Ажил, ажил гэсээр байгаад хүүхдээ ч олигтой анхаарч чадахгүй юм. Тэр өдөр манайд очиж хүүхдэд эм бичиж өгсөнд би их баярласан шүү.

Ээж нь байхгүй юм болохоор хүүхдэд тавих анхаарал над дээр тохогдож байгаа юм. Би гэдэг хүн завгүй болохоор их хэцүү байдаг юмаа. Тэгээд чамд баярласнаа илэрхийлж байгаа ухаантай юм гээд нэг дөрвөлжин хайрцагтай юм өгөв. Нараа зүгээр зүгээр гэхэд ав ав. Миний сэтгэлийн талархал гэж үзээд авалдаа гэв. Чи орой завтай бол надтай нэг газар очиж хоол идэхгүй юу. Би чамайг урьж байна. Чи зөвшөөрөх үүгэж асуухад Нараа нэлээд зовсон янзтай би чадахгүй байхаа. Манайх бүр Баянхошуунд байдаг болохоор оройн ямар нэгэн арга хэмжээнд би ер орж чаддаггүй юм гэхэд, танайхыг би мэднээ тэр талаар зоволтгүй, орой чамайг машин явуулаад авахуулчихъя. Чи хаана байх вэ. Цагаа хэлчих. Гэнэт ийм асуудалтай

тулгарсан Нараа жаахан сандарч

-За яахав дээ. Би 7 цагт Баянхошууны эцсийн буудал дээр хүлээе гэв. Ийнхүү сүүлийн хэдэн жил бүсгүй хүнтэй болзоогүй явсан Цэнгэлийн сэтгэл ихэд хөдөлж, аливаа юманд шулуун шударга нь дээр байх. Би бүх үнэнээ хэлье. Алийн болгон ганцаар явах вэ. Хоёр муу хүүхэд минь ч бүсгүй хүний мөрөөдөл болчихож. Нэгэнт л ээж нь хүнтэй суугаад амьдралаа бодсон юм чинь хүүхдүүддээ ч учир байдлаа хэлж ний нуугүй ярилцая. Нараа хэрэв зөвшөөрвөл манайх гэдэг айл сэхээд л явчихна гэсэн шүү юм бодож үлдэв.

Цэнгэл өөрийн хуучин хоёр өрөө байшингаа гадаадын хүн суулгахаар тохижуулан засаад сайхан болгосон учир тэндээ хоол хийж, жимс, зууш, алим, чихэр гээд бүсгүй хүний идэх дуртай бүхнийг бэлэн болгосноо санаж энэ орой нэг тухтай сууя даа. Хүн байна даа бас ая зүйгээ олж амьдралаа боддог байгаа даа гэж дотроо нилээд баяр хөөртэй байснаа, гэнэт, угуй ээ Нараа зөвшөөрөхгүй бол яана. Манай орлогч хэлэхдээ Нарааг хоёр настай хүүтэй нөхөр нь Солонгос яваад алуулчихсан, зовлон үзсэн, бас их зугээр хүүхэн гээд байсан ямар байсан ч үзээд л алдая. Хоёр зовсон хүн амьдарч болох юун магад гэж сэтгэлээ засав. Тэгээд орой болохыг хүлээж цагаа харан байн байн тасалгаандаа босон суун эргэлдэнэ....

...Орчин үеийн сайхан зассан тохилог өрөөнд явган ширээний ард Наран, Цэнгэл хоёр зэрэгцэн сууна. Хэн хэн нь бие биенээсээ цэрвэн нэлээд цэмцэгнэн байх нь яах бол гэсэн болгоомжлол хэн хэнийх нь сэтгэл зүрхийг зовоож байгаа нь илэрхий. Цэнгэл өдөр баарнаас захиалж авчирсан хоолоо халааж, олон төрлийн зууш тавьж, ширээ бүх юмаар дүүрсэн хойно

-За би чамтай ний нуугүй ярилцаж сайхан танилцая гэж бодсон юм. Амьдралд их л юм үзэж байна. Бүр сүүлдээ эхнэртээ хаягдаж хүртэл үзлээ. Одоо яая гэх вэ дээ. Аль хэцүү юмыг тэр гэх вэ,

-За чиний эрүүл энхийн төлөө ажлын их амжилт амьдралын сайн сайхан, бас бид хоёрын сайхан танилцсаны төлөө ууя гээд хундага дүүрэн дарс цэлэлзтэл барилаа. Эхний хундагыг заавал ууна шүү. Харин дараагийн хундагуудыг бол би шахахгүй ээ. Би ер нь бас архи уудаг эмэгтэй хүнд тийм ч их дуртай хүн биш ээ. Харин чамтай танилцаж байгаа энэ мөчид бол ганц хоёр хундгыг уулгүй яахав. За уугаарай гээд өргөв. Нараа ч бараг нүдээ аних шахан нөгөө хундгыг тогтоов. Дотор нь халуу оргиж үл мэдэг нүүр нь улайж суув. Тэгээд Цэнгэл яриагаа ийн эхлэв.

-За танилцаж байгаагийн хувьд би чамд өөрийнхөө амьдралыг ний нуугүй л ярья. Эхнэр маань хэдэн жилийн өмнө Эрээн лүүнаймаа хийж гахай чирч явсаар нилээд удаан хугацаа өнгөрч байтал сүүлдээ нэг залуутай танилцаад бур тхлжтэйгээ суухаар болж гэр орондоо ч цөөн ирж, бур нэг өдөр ирэн чинь бүх юмаа ачаад, чамаас саллаа гэж бичиг үлдээгээд явчихсан байсан. Ингээд би амьдын хагацалд унаж, хоёр хүүхэд минь ч өнчрөн үлдсэн дээ. Аав ээж хоёр минь байгаагүй бол ч би бур сүйрэх байлаа. Тэгээд тийм явдал болно гэж бодоогүй, авгайдаа итгэж явдаг хүн чинь гэнэт ийм уйл явдалтай учраад ёстой л барьц алдаж сэтгэлээр унаж, бараг долоо хоног ажилдаа ч очилгүй архи ууж гутарч, ганцаараа уйлж их л юм болсон. Тэгээд нэгэнт хүн орхиод явчихсан юм чинь хоёр муу хүүхдээ, ээж ааваа бодож өөрийгөө татаж авах хэрэгтэй юм байна гэж ухаараад л сэтгэлээ барьсан. Манай авгай тийм их гоё хүүхэн биш. Сэргэлэн сайхан л хүүхэн. Тэгээд ямар гээчийн ид шидтэй нөхөр таарсан

юм бүү мэд, гэнэт л өөрөө тэгээд салаад явчихсан. Улс амьтны ярих нь сүрхий сайхан залуутай л машин дотор заларч явна гэж дуулдах юм. Тэр хүн амьдралаа бодож өөрөө сонгосон жаргалаараа л болог гэж би бодоод хойноос нь нэхэл дагал болсонгүй. Харин хоёр хүүхдээ л өрөвдөх юм. Эхийн хайр гэдэг юугаар ч сольшгүй юм байдаг болохоор тэр хүүхдүүдийн сэтгэл ямар л олигтой байгаа гэж дээ. Гэхдээ миний хүүхдүүд ухаантай хүүхдүүд юм билээ. Эртүүд нэг орой гурвуулаа сууж байсан чинь охин маань

-Ааваа бид хоёрт нэг ээж хэрэгтэй байна гэдэг байна шүү. Нэгэнт л манай ээж ирэхгүй болчихсон юм чинь бид хоёр өөр ээжтэй болмоор байна гэж намайг сандаргадаг юм байна. Надад хэлэх ч үг олддоггүй. Ээжтэй болох амаргүй, та хоёрын төрсөн ээж чинь орхиод явчихсан байхад ямар ээж хаанаасаа олдох юм бэ л гэж арай чуу л хэлсэн шүү. Хүүхдүүд гэдэг бас их юм боддог улс шиг байгаа юм. Энэ аав ганцаараа хэцүү байна гэж ч бодоо байлгүй дээ гэхэд Нараа харин тийм дээ. Тэдэнд бас эхийн хайр үгүйлэгддэг байлгүй дээ хөөрхий гэж аяархан хэлэв. Цэнгэл

-за миний амьдрал гэдэг нэг иймэрхүү л байна даа. Харин чи өөрийнхөө талаар яриач. Би хүний нууцыг задлахгүй ээ гэв.

Наран уртаар санаа алдаж миний амьдрал ч бас их зовлонтой доо. Төгссөн жилээ хурим хийж нэг залуутай суусан. Тэр маань монголд амьдрал алга гээд хамаг гэр орноо зараад л Солонгос явж мөнгө олж ирнэ гэж надтай зөрөөд явсан. Тэгээд л хүний нутагт хүнд алуулсан, Хөөрхий минь би тэгээд нэг хүүхэд түүний хэдэн зурагтай л үлдсэн. Хорвоо хатуу юм билээ. Би багаасаа л өнчирсэн. Эцэг эхийн хайр гэдгийг үзээгүй. Харин ганц муу эгч минь л намайг өдий зэрэгтэй авч явна. Сургууль төгсгөж мэргэжилтэй болголоо. Хурим хийлгэж гэр оронтой болгосон. Түүнийг нь би ингээд балалчихсан. Одоо тэгээд хоёр настай нэг хүүтэйгээ эгч дээрээ л амь зууж байна. Өнчрөн үлдэхийн зовлон, үхүүлж ганцаардахын зовлон, аль алиныг нь л үзлээ дээ. Цаашдаа ямар зовлон тохиолдохыг хэн мэдлээ гэж нулимсаа арчив.

Цэнгэл түүнийг өрөвдөж хөөрхий бас л зовсон амьтан юм даа. Надтай амьдарвал би жаргаахыг л бодно доо гэж дотроо 'бодон,

-За чи бид хоёр аль аль нь зовлон үзсэн л юм байна. Одоо энэ өдрөөс хойш зовлонгоо хуваалцаж, жаргалтай амьдрахыг бодноо хө. Алив хундагаа барь. Би ч уул нь хорхойд хоргүй хүн л гэж өөрийгөө бодож явсан юм. Гэтэл дэргэд минь хүн тогтохооргүй амьтан байсан юм байлгүй гээд инээв. Ийн тэр хоёр зовлон, жаргал ярьсаар шөнө дөл болтол сууж

-за тэгээд хоёулаа сайхан танилцлаа. Манайхаар ирж байгаарай. Бас манай аав ээж, миний хоёр хүүтэй танилцаарай. Чамд их баярлалаа. Миний урилгыг хүлээн авч ирсэнд чинь гээд

-за гадаа машин байгаа. Чамайг гэрт чинь хүргээд өгнө..... Цэнгэлхаалган дээрээ очоод их баярлалаа Нараа гээд гарыг нь барьж духан дээр нь зөөлөн үнэрлээд тэр хоёр гарав. Машинд суумагц Цэнгэл би аавынд буучихъя. Чи Нарааг хүргээд өгчих гэв.....

Үүнээс хойш өдөр, сар өнгөрсөөр нилээд хугацаа болжээ. Зургаан сарын нэгэн тогтуун сайхан өглөө Цэнгэл хоёр хүүгээ аваад Нараагийн гадаа очиж зогсоод жолоочоо

-чи ороод Нарааг хүүтэйгээ гараад ир гэж хэл. Би өчигдөр салхинд гарья гэж хэлчихсэн юм гэв. Жолооч тэдний рүү ороход Нараа хүүдээ хувцасыг нь өмсгөчихсөн гарахаар завдаад зогсож байв. Тэр гурвыг гарч ирэхэд Цэнгэлийн охин Нараагийн хүүхдийг хараад

-ямар хөөрхөн хүүхэд вэ? Ийм дүүтэй болохсон гэж дуу алдав. Нараа сайн байцгаана уу? гээд машинд суув. Тэд Шарга морьт руу чиглэн давхив. Эцсийн буудлаас нэлээд хойш яваад хоёр давхар сайхан байшингийн үүдэнд очиж зогсов. Цэнгэл байшингийнхаа доод давхрын нэг өрөөний цонхны хаалтыг нь авч галын өрөөний ус буцалгагчийг залгав. Гадаа Нараагийн хүүг хоёр хүүхэд нь ээлжлэн тэвэрч яасан хөөрхөн юм бэ? Чи энэ шар цэцгүүдийг хараа гоё байгаа биз гээд л нөгөө хүүхэд нь баацагнан гүйж цэцэг сонирхон их л хөгжөөнтөй байцгаав. Удалгүй ширээн дээр идээ будаа, амттан, хээрийн зууш бэлэн болж Наран ч хүүхдүүдээ орцгоо хоолоо идэцгээ гэж урьхан дуугаар хэлэв. Бяцхан хүүч хөөрөн баясаж орж ирэхэд Цэнгэл тосон авч өндөр өргөөд чи бишүүрхдэг хүн үү үгүй юу гээд үнсэв. Хүү инээн баясан Цэнгэлийн хүзүүгээр тэврэн ажиггүй дэвхцэж байв. Өө энэ чинь их сайхан зантай хүү байна. За хоёулаа юм иднээ гээд өвөр дээрээ авч суулаа. Нараа хүүд юу өгвөл дээр вэ гэхэд Наран

-хиам бариулчих давгүй зулгаагаад идчихдэг юм гэв. Ийнхүү энэ сайхан өдөр тэд яг л нэгэн гэр бүлийн хүмүүс шиг сайхан хооллож эрүүл сайхан агаарт амарцгаалаа. Цэнгэлийн хоёр хүүхэд хүүг өргөн гүйж гурвуулаа тоглоод яг л нэг айлын хүүхдүүд шиг байх нь бурхан тэднийг учруулсан мэт Наранд санагдаж, ийм хүнтэй суучихвал ч мөн сайхан даа. Даанч надад амьдрах тухай ярьдаггүй. Их л сонин хүн юм даа. Өнөөдөр орой бид хоёрыг гэртээ урих болов уу? Эртүүд аав - ээжтэйгээ танилцуулаад сүйд л байсан. Тэд нь сайхан л хүмүүс байсан даа гэх зэргийн юм бодож суулаа. Хэдэн хүүхэд нь гадаа тоглоод жолооч нь машинаараа оролдоод, тэр хооронд Цэнгэл цонхоороо харчихаад -Үгүй ээ энэ гурвыг ээ. Бүр нэг сайхан баясаж байна.

-Харин тийм ээ. Ёстой нэг бахаа ханатал тоглож байна даа. Энэ хоёр дүүд их дуртай хүүхдүүд байгаа юм. Хоёулаа нэг дүү л гаргаж өгөхөөс гэж Цэнгэл их л баяртайгаар өгүүлэхэд Наран ичингүйрсэн маягтай инээмсэглэн ташуу харав. Тэр хоёрын сэтгэлд хайрын бяцхан гал ноцож байгааг хэн хэн нь мэдэрсэн боловч итгэхэд бэрхтэй үйл явдал гэдгийг жинхэнэ дээрээ тун ч таахад бэрх таавар байлаа. Тэр хоёр хоолоо идэцгээ гэж дуудлаа. Хүүхдүүд ч дүүгээ тэвэрсээр орж ирлээ. Ийнхүү нэгэн бүтэн сайн өдрийн үйл явдал тэр хоёрын ирээдүйн амьдралын эхэн болж өнгөрч байгааг хэн хэн нь тааж мэдээгүй ч сэтгэлд нь нэг л бүлээн дулаан уур амьсгал бий болж байгааг хэн хэн нь гадарлаж байснаас амьдрах итгэлийн гал аль алиных нь зүрхэнд асан бадамлаж байв. Оройхон хэрд хот руугаа буцах болж бүгдээрээ юм хумаа янзалж, Цэнгэл ч дүүгээ хувцасла гэж хоёр хүүхдэд хэлэхэд тэр хоёр түүнийг өхөөрдөн хувцасыг нь өмсүүлж Эрдэнээ одоо явья гэхэд тэр хүүгийн нэрийг Эрдэнэ гэдэг ажээ тэр бөөн баяр болж дэвхцэнэ. Цэнгэлийн охин түүнийг тэврэн гарч машинд суулаа. Тэд эхлээд Цэнгэлийн аавын гадаа ирж хоёр хүүхдийг нь буулгаад цааш эртүүдхэн Нарангийн ирсэн байшингийн өмнө очиж зогсов. Цэнгэл Наран хоёр хүүгээ авч буухад, жолооч

-даргаа хэдийд ирэх вэ гэхэд өглөө бүр эрт ирээрэй энэ хүүг яслид хүргэж өгнө гээд хэзээ язааны нэгэн гэр бүлийн хоёр шиг Цэнгэлийнх рүү орлоо. Гэртээ ормогц Цэнгэл хүүгийн хувцасыг тайлж, хөргөгчнөөс тараг гарган аягалж Эрдэнэд өгөв. Хүү ч учиргүй баярлан ууж уруулаа сахал мэт тарганд дүрчихсэн, цагаан өвгөн шиг юм болчихсон инээж суув. Наран



-Пээ энийг хараач ээ гээд дотроо их баяртайгаар инээмсэглэв. За ингээд гурвуулаа гэртээ хүрээд ирлээ дээ. Ингээд л амьдрал эхлэх нь энэ дээ. Чи зөвшөөрч байна уу гэж Цэнгэлийг хэлэхэд Наран дув дуугүй бүлх залгисан мэт болж доошоо харан суув.

Жаахан дуугуй байснаа нэг том санаа алдан би ч мэдэхгүй л байна, юу ч гэсэн эгчтэйгээ ярьж зөвлөө дөө. Намайг өдий хүртэл тэжээж авч явсан тэр хүний үгийг л дагана даа. Өөр яах ч билээ гэж арай ядан өгүүлэв. Эгчтэй чинь би аль хэдийн ярьж тохирсон шүү дээ.

- Миний муу дүүг хүний зэрэгтэй аваад л явбал болоо шүү дээ. Танд би итгэж байна. Зовлон үзсэн болохоор нь би муу дүүгээ өрөвдөөд юу ч хэлж чаддаггүй юм. Ханьтай болооч гэж хэлэх гэж бодсоор л өдий хүртэл хэлж чадаагүй л яваа юм. Харин тантай учирсныг нь дуулаад би баярлаж байгаа шүү гэж байна билээ. Тэгэхээр чи санаа зовох явдалгүй. Би өнөөдрийг сайн өдөр болохоор чамайг гэртээ авчирна гээд хэлчихсэн. Чи тайван бай. Одоо бол чи энэ гэрийн эзэгтэй гэж л өөрийгөө бод. Айлын эзэгтэй ямар байх ёстой вэ. Тэр л маягаар бай. Манайд юм бүхэн бий. Харин чи л дугаад байсан юм гээд Нарангийн бэлхүүсээр Тэврэн хацрыг нь зөөлхөн үнсэв. Би чамайг айлгахгүй. Хэзээ чи надад итгэж дотно болсон тэр цагт л би чиний өвөрт орно. Чамайг дургүй байвал заавал надтай амьдар гэж албадахгүй. Дуртай цагтаа чи харьж болно. Харин би чамд хайртай шүү гэдгээ л хэлмээр байна. Чи намайг хайрлах эсэхээ өөрөө л мэднэ биз. Надтай амьдармааргүй байвал үнэнээ хэлээрэй. Би чамд гомдохгүй. Хүн гэдэг чинь өөрөө өөрийнхөө хуссэнээр л байх учиртай. Тиймээс чи өөрийнхөө дураар л шийд.

Харин би чамд итгэж байгаа имү. Чи бид хоёр ингээд амьдрахад болохгүй юм юу байхав. Хоёулаа л зовлон үзсэн хоёр. Бие биеэ л сайн ойлговол болох нь тэр. Миний хувьд гэвэл дэндүү хэнэггүй эр хүн гэх үү дээ. Харин хүнд итгэвэл итгэсэн шиг итгэж, амьдарсан шиг л амьдрахыг л бодно. Ийм л байна. Чи тэгээд сайн бодол доо. Өө хүү маань үүрэглэж байна. Тийш өрөө рүү оруулж унтуулаатах гэв.

Нарангийн дотор олон бодол эргэлдэж, энэ эрэгтэйчүүд ер нь горьгүй улс даа. Надад үнэхээр сайн байна уу

-эсвэл үзээд өнгөрье гэж бодож байна уу? Уул нь хүмүүс сайн хүн л гэлцэх юм. Би яаж шийдвэл дээр юм болдоо. Ингээд л эднийд ирчихээр амьтан хүн юу гэх бол. Нөгөө Нараа чинь даргын хормойноос зүүгдээд авч гэх болов уу? Эсвэл болж дээ хөөрхий гэх болов уу? Манай нөгөө боловсон хүчний Цэцгээ юу гэж бодох бол. Тэр байнга л даргыг эргүүлж байдаг гэж манайхан ярьдаг. Харин дарга тэрнийг тоодоггүй юм гээд л инээлдэж байдаг даа. Намайг бас юу гэх болдоо гэж тэрүүхэн хооронд элдвийг эргэцүүлэн бодно.

Наран хүүгээ жижиг өрөөнд унтуулаад гарч ирэхэд Цэнгэл аль хэдийн диван сунган ор засчихсан, за унтдаа Нараа. Чи ядарч байгаа байх. Би зүгээр хажууд чинь жаахан байя гээд угаалгын өрөө рүү оров. Наран өрөөний гэрлийг унтрааж хананы жижиг чийдэнг асаагаад оронд оров. Удалгүй сайхан үнэр сэнхийж Цэнгэл орж ирээд Нарангийн хажуугаар хэвтээд духан дээр нь үнсэн духыг нь илж, тэврээд чамд би итгэж байгаа шүү. Итгэхээр ч барахгүй бас хайртай шүү. Чи аягүй бол үнэмшихгүй л байгаа даа гээд мишилзэв.....

Цэнгэл тэр хоёрын ийнхүү эхэлсэн амьдрал хэрхэн цааш үргэлжлэхийг хэн ч тааж мэдэхгүй

боловч тэд харцаараа бие биенээ дуудан хайрын гал хэн хэнийх нь зүрхэнд ассан гэдэг нь маргашгүй үнэн билээ. Цэнгэлийн хувьд эхнэртээ хаягдсан боловч харин Нарангийн харцанд өртөж, цэл залуухан түүний цэцгэн үнэрт согтож, гоо биеийг нь тэврэх аз тохиосон нь бурхнаас заяасан тавилан гэлтэй. “Санаа сайн бол заяа сайн” гэсэн мэргэн үг байдаг нь яг Цэнгэлд зохилтой ажгуу.

Зүрх зүрхээ дагадаг нь

Зүүдэн хорвоогийн жам

Зөн совингоор учирдаг нь

Зөвхөн чиний минь хайраа...

гэж нэгэн найрагчийн бичсэнчлэн Цэнгэлийн амьдрал цэцэглэн дэгжих замдаа оржээ.

.. Санасанаар болдоггүй хорвоо. Тохилог сайхан өрөөнд Заяат ид нойрон дундаа хөлбөрнө

... Уурхайн шороон нүхэнд өдөржин малталт хийж олсон алтаа шигшин цайруулж, өдөржин завгүй. Сүүлдээ алт л олж байвал алд бие, амь нас хамаагүй болж, дуусашгүй эрлийн далайд умбаж, баяжихсан гэж бодохоос нойр нь ч үл хүрнэ.

Түүний дотор хэнээс ч дутуугүй амьдарна, өдий насандаа жаахан зовсон ч өтөл насандаа жаргах л юм чинь гэсэн гэнэн бодол дотрыг нь гижигдэнэ... Шөнийн гурван цаг болж байхад түүний жигдхэн амьсгаа архины үнэртэй холилдон Ганиймаагийн сэтгэлийг тавгүйцүүлнэ. Заяат холын зүүдний манан дунд дэндүү жаргалтай хөвнө. Хааны шилтгээн шиг олон өрөөтэй, хоёр давхар харшид алтан хээтэй сэнтийд заларчихсан, хэдэн үйлчлэгч нар өмнө нь идээний дээдийг өрж,

-Эзэнтээн та юу зооглох вэ? гэж бөхөлзөн нахилзан асууна. Авгай нь алтан хоргой эмжээртэй цэнхэр торгон дээл өмссөн, гэзгээ дээш нь шууж сувдан хавчаар хатгасан үзэгдэнэ. Манай авгай ч гоё л харагдаж байна шүү. Наймааны муу вагонд анх танилцаж байсан хүүхэн гэхээргүй л сайхан харагдаж байна. Хөөрхий хүний үр намайг татаад нөхөр хүүхдээсээ салж бас л зовж яваа амьтан гэж бодохын сацуу нэг үйлчлэгч сайхан бүсгүй алтан жүнзэнд дарс хийчихсэн, - Та үүнийг уучих гээд "түүнд өглөө. Тэр бүсгүйн талимаарсан нүд ид арван найман насны өнгө үзэсгэлэн яахын аргагүй сэтгэлийг нь татах аж. Эргэн тойрон ажсан чинь авгай нь алга. Өөр бусад хүн ч алга. Заяатын сэтгэл сэргэж, алив хоёулаа ууя гэж нэг хундага барин нөгөө үйлчлэгч бүсгүйд өгөв. Бүсгүй их л айж цочирдон

-Ахайтан ирвэл яана. Эзэнтэн минь би уухгүй гээд хундгыг ширээн дээр тавиад эргэх гэтэл мань хүн түүнийг тэвэрч аваад сэнтий дээрээ даран авч хүчээр болгох гэж оролдож байтал, эхнэр Ганиймаа нь орж ирээд

-Муу новшийн амьтан гэж үйлчлэгчийн үсийг зулгааж зодон самардахад Заяат:

-Болиоч ээ, наад бүсгүй чинь буруугүй ээ. Ийм сайхан амьтныг битгий нуур нүдийг нь урчих.

Наадах чинь буруугүй гээд орилтол гэнэт хажууд нь хэвтэж байсан Ганиймаа

-юуны чинь буруугүй, юуны чинь сайхан амьтан, чи бас намайг залилж гадуур муусайн охидтой самуурч явдаг байх нь ээ. Яасан увайгүй балиар амьтан бэ? чи гээд сэгсийсэн үстэй, хөх дэлэнгээ унжуулсан хачин шулмас шиг юм зогсож байв. Нойрноосоо ч гүйцэд сэрээгүй, сайхан зүүднээсээ ч салж амжаагүй Заяат нүдээ нээх аядтал нь гэрийн шаахайгаар толгой дундуур нь татаж учир зүггүй нүдэхэд Заяат

-Болиоч ээ би зуудлээд л дэмий ярьчихаж гэсэн чинь, Ганиймаа галзуурсан мэт дайрч, чи тэр сайхан бүсгүйтэйгээ амьдар. Ингээд амьдар гээд учир зуггүй балбаж гарав. Заяат орон дээрээ босож суугаад

-Үгүй ээ чи болиоч ээ. Энэ чинь зүүд байхгүй юу даа. Зүүднээс болоод хүн зодоод байхдаа яадаг юм, гээд ихэд дургүйцэхэд

-Чи битгий хуцаад бай. Чи хүний амьдралыг үрэн таран хийчихээд одоо болохоор муусайн банзал охидыг зүүдэлж жаргаад байхдаа яадаг юм гээд хэрэлдэв. Тэгснээ Заяат эвлэрэхийн тулд Ганиймааг НҮЦГЭН бэлхүүсээр нь тэврэн орон дээр дээш нь харуулж тавиад өөрөө дээр нь гарч бушуухан ум, хумаа нийлүүлэн ширүүхэн түлхэж, чи ингээд уурла, ингээд уурла гээд хэд хэд оцогонон түлхэхэд Ганиймаа яаж ч чадахгүй үл мэдэг жаахан гийнан амьсгаадсаар сая тайтгарч, тэр хоёр нэгээхэн агшинд орчлонг умартаж хоёр биеэ тас тэврэн унтав.

Нар гийн тусах тэр агшинд сэрж хам хум хувцаслаад Заяат цай ч ууж амжилгүй уурхайн шорооруугаа тортой юмаа барин гарав.

Ганиймаа энэ муу Заяат яахаараа бүсгүй хүн зүүдэлж, сайхан амьтан гээд сүйд болдог байнаа. Үгүй ээ зүүд гэж мөн хачин юм шүү. Би бас эртүүд Эрээний муу Ванийг зүүдлээд өмхий амаараа намайг үнсэж байна гэж зүүдлээд сэрэхэд Заяат хажууд хурхираад унтаж байсан тэр зүүднээс хойш сэтгэл нэг л эвгүй, Эрээний муусайн хужаануудыг харахаас дотор нэг л эвгүй болж байсан.

-За за зүүдэлсний нь төлөө муу Заяатыг зовоогоод ч яах юм гэж амандаа үглээд чанасан хоолоо халуун саванд хийн цайтайгаа барин Заяатын араас гарав. Сүүлийн хоёр жил энэ хоёр нилээд баяжиж тэндээ товхийсэн гоё байшин худалдаж аваад өвч бүрэн тавилга тавьж хөдөөдөө л байхгүй баячуул гэж яригдах болжээ. Тэр өдөр Заяат бас хүч чадал нэмсэн юм шиг эргийн хэсэг шороог өм өм татан ломдож их шороо гаргав. Оройхон хэрд бөөн шороон дотроос эрхий хуруун чинээ цул алтан тогтоц олоод туйлгүй баярлаж, урд шөнийн зүүд чинь олз авчирсан сайхан л зүүд байж гэж дотроо бодоод

-Ганий, энийг хараач гэж нөгөө олсон алтаа үзүүлээд тэр учир зүггүй баярлаж

-Миний муу өвгөн чинь хоншоортой хүн юмаа гээд баруун хацар дээр нь үнсэв. Тэр хоёр энэ удаад олзоо хэнд ч хэлсэнгүй чимээгүй л байв. Муусайн юмнууд атаархаад яршиг удна гээд чив чимээгүй өнгөрөхөөр тохиров. Газар шороо ч тэр хоёрт хэдэн жил өгөөжөө өгч гоё сайхан байшинд тухлаж, Заяат ч хамраа сөхөөд их додигор болж, хавь ойрынхон ч энэ нэг гуяа

ганзгалж ирсэн хоёр юм сэхлээ шүү гээд нүд үзүүрлэх болжээ. Монголчуудын тамын тогооны үлгэр ямар дуусах биш нэгийгээ жаахан сэхэхээр л доош нь дарах өвчин нь хөдөлцгөөж Заяатыг элдвээр муулж, бэлэн амалсан хачин амьтан гээд аль эрт “бэлэн заяа” гээд хочилчихсон байжээ. Нөгөө анх энд ирэхдээ найз байсан Батаагийнхаараа ч орохоо больж муусайн гуйлгачин юмнууд царай алдсан, тэр идэж байгаа хоолыг нь, нохойн хоол шиг заваан гээд л урд нь тэднийхээс хоол идэж байгаагүй юм шиг л их л сүрхий муулж гарна. Тэгээд л бид хоёрын энэ байшин энэхэн хавьдаа ордон шүү дээ гээд баярхаж дэврэнэ.

Харин хотод барих байшингаа л бүр сайхныг бариулна. Дотрох ханыг нь алтадсан цаасаар наалгана. Тэр байшинг барьсан цагт хотын баячуул ч мэлрэх л болно. Ер нь гарч өгнө дөө гэх зэргээр элдвийг бодон шороогоо өм өм цохино. Нөгөө олсон цул алт ч бас л багагүй юм унагах бий вий. Газар дэлхий хүртэл Заяатын өвөрт бөөн бөөн алтаа шидэж байхад би баяжиж л таараа. Тэр цагт уржигдарын зүүдэнд орж ирдэг шиг сайхан охид ч миний өвөрлүү мөн цуварч л таараа. Тэднээр зугаагаа гаргаад ёстой ч нэг мөнгөн дээр тогтдог хорвоо юм бол мөдхөн би тэр мөнгий чинь нэг жаргалын үүд болгохыг мэдэх байлгүй дээ. Тэр цагт энэ муу Ганиймаа юу юм бэ. Ганцхан няслаад л болоо шүү дээ гэх шүү юм бодож байтал, цай хоол барьчихсан Ганиймаа хүрч ирэн,

-Цайгаа уу чи одоо ядарчихлаа шүү дээ. Хэд хоногоос энд хоёулаа хөлсний хүн авч газраа ухуулая. Т эгээд чи яахав дэргэд нь хяналт тавьж хааяа нэг ирнэ л биз гэхэд

-Больж үз. Тэнэг минь. Энэ газар чинь алтны судалтай юм шиг байгаа юм. Тэгэхээр хүнээр ухуулбал олсон бөөн бөөн алт түүний л өвөрлүү орно шүү дээ. Тэгэж ч амандаа орсон өөхийг хэлээрээ түлхэхгүй шүү. Чи жаахан ухаантай бодож байгаач гээд хөлсөө арчиж цайгаа уухаар суув. Түүний ухаж байсан мөргөцгийн шороо унан чад пад дуугарч байх нь сэтгэлд нэгийг бодуулах авч Ганиймаа

-Өө яанаа тэр шороо нурж байна. Ямар аймаар юм бэ? Чи цааш ухахаа түр болино байгаа, шороонд дарагдчихвал яах юм гэхэд

-Хцс тийм азгүй юм гэж хаана байсан юм. Энэ зах зээл чинь хэн юу чадаж байна түүнийгээ л хийх хэрэгтэй болоод байна шүү дээ. Тэгэж байж л хүнээс дутахгүй амьдарна шүү дээ. Нэг үгээр хэлбэл ажиллах л хэрэгтэй гээд том том үмхлэн хоолоо иднэ. Хоёр аяга цай уучихаад шорооруугаа ханцуй шамлан оров. Ганиймаа шороо шигших зуураа үгүй ээ энэ муу чинь хөөрхий миний төлөө үхэхээ мэдэхгүй л зүтгэж байгаа амьтан. Би Цэнгэлтэй байсан бол өдий дайны явахгүй дээ. Энэ маань ч хөөрхий амьдралынхаа төлөө голоо тасартал зүтгэж байгаа хүн шүү. Даанч би хоёр муу хүүхдээ л санах юм. Өдийд яаж шуу байгаа бол. Цэнгэлийн аав, ээжийн заваан хоолыг идсэн болоод л нэг халтар царайлсан юмнууд гүйж яваа байх даа. Энэ хэдэн жилд аль хэр томроо бол. Тэднийхээ барааг харалгүй мөн их удлаа даа. За яахав жаахан сэхдэг юм бол хоёр хүүхдээ өөр дээрээ авсан ч яахав дээ. Даанч Заяат хүүхдэд их дургүйдээ. За яахав. Энэ мууг аргалж болох л байх. Ер нь хүн мөнгөтөй л байвал бүх юм бүтэх юм чинь. Аяндаа нэг миний гарт ороод ирэх байлгүй дээ гэх аятай юм бодоод шигшүүрээ аяархан хэмээр хөдөлгөх аядана. Энэ алтаа гэж мөн ид шидтэй эддээ. Үнэхээр ч бид хоёрыг дэгжээсэн шүү дээ. Одоо бид хэнээс юу горьдох юм бэ. Ёстой гайгүй байлгүй. Муу Цэнгэлийг төсвийн хэдэн төгрөг дээр эргэлдэж байхад нь бид хоёр алтан шцлтгээнд суучихсан “Хэлбэл миний дур, хийсгэвэл тэнгэрийн дур” гэгч Эр бүхнийг өмнөө сөгдүүлэх л

болно доо гэж өөртэйгөө ярьж Ганиймаа их л ихэмсэг байдалтай байна. Энэ хоёрын сэтгэлд зөвхөн баяжих л гэсэн ганц бодол өдрийн бодол, шөнийн зүүд болон орж ирдэг аж. Ийнхүү хоёр амраг баяжихын хүслээр жигүүрлэн бараан цагаантай хорвоог анзаарах ч чөлөөгүй л байх юм...

Ганиймаа алтаар олсон хэдэн төгрөгөө арвижуулах гэж Эрээн хотын зүг жолоо залав. Нэгэн орой хажуу айлын охин хонины гэдэс бариад орж ирлээ. Заяат сайхан ааш гарган за суу. Айл хүний амь нэг гэж үнэн юмдаа би ганцаараа байгаа болохоор хоол ч хийгээгүй байж байтал ингээд халуун гэдэс ороод ирлээ. Яасан сайн юм гэсээр л их л эелдэг угтаж авлаа. Тэгээд идээ тавин өгч савыг нь суллаад охиныг гарах гэтэл барьж аваад орон дээрээ өргөн тавьж, чи сайхан охин болжээ. Ах нь чамд хайртай байдаг юм шүү. Эр хүний сэтгэлд яг л чам шиг охин л анхны харцаар хайр зарладаг юм гээд үнсэн үмхэлж юу хуугүй өмдийг нь тайлж

- ахаа болиоч гэж орилсоор байтал нь нөгөөхөө аль хэдийн шургуулж амжаад аяархан аяархан түлхэж сайхан байгаа биз. За алив нэг сайхан тавиатах гээд их уян зөөлнөөр илбэхэд охин тачаал хөдөлж дороос нь аяархан түлхэж эхлэв.

Удаан загас наадуулсны эцэст охиныг босгож саванд нь баахан чихэр хийж өгөөд ирж байгаарай, ах нь чамайг жаргаана шүү. Чи бид хоёр нууцаа л хадгалах хэрэгтэй гэж дахин дахин хэлээд түүнийг нэг сайн үнсээд гаргав. Эр хүний саваагүй зан гэдэг ийм л байдаг хойно доо яая гэх вэ?. Энэ муу охин бас сүрхий тачаангуй золиг юм. Тэр жаахан телевиз харж байгаад - за унтаж амрая маргааш ахиухан шиг ажиллахаа бодъё. Амьдрал муугүй байгаа дээр нь жаахан зүтгээд авдаг хэрэг гээд унтахаар хажуулав.

Өдөр хоног урссаар дахин хэдэн сар өнгөрөв. Тэгтэл уурхайд шинэ дарга ирж энэ уурхайн орчин тойронд ажилладаг хүмүүсийг цөмийг татан буулгах гэнэ, хүний амь нас эрсдэж мэдэх энэ ажил аюултай. Манай уурхай хувиараа ажиллаж байгаа хүмүүсийн хөдөлмөр хамгааллыг хариуцаж чадахгүй. Тиймээс цөмийг татан буулгах хэрэгтэй гэж шийдвэр гаргажээ. Гэсэн ч хүмүүс ашгийн төлөө ажилласаар л өглөө цагдаа хөөгөөд тараахад үдээс хойш өдий төдий хүн газар ухаж л байдаг байна. Заяат ажлаасаа ирээд

-Өнөөдөр нэг муу цагдаа ирээд хойт мөрөгцөгт хүн амины хэрэг гарсан, шороо нураад нэг хүн дарагдаж үхсэн. Уурхайн захиргаа энд ажиллагсадыг цөмийг буулга гэсэн гээд баахан л юм боллоо.

Уурхайд нэг шинэ дарга ирсэн юм байх. Тэр нь жаахан хэнхэг амьтан байж л дээ гэхэд Ганиймаа

-Өө тэгээ юу үнэхээр нурвал ч аюултай л даа. Чи ч гэсэн хэдэн өдөр болимоор юм цаагуураа газар дэлхий нь хөдлөөд ч байгаа юм билүү яаж мэдэх вэ? гэв. Заяат

-за юу гэж дээ тийм азгүй юм гэж хаа байхав дээ. Би ч бүр сүүлийг нь харж байж л болино шүү. Тэгж амархан бууж өгөхгүй шуу. Нэг хэнхэг дарга ирсний төлөө л ажлаа орхино гэж юу байсан юм. Харин маргааш нилээд шаргуу үзэж тарнаа өнөөдрийн тэр газар сайн олдоцтой юм билээ.

-За чи өөрөө л мэддээ. Элдэв юм болбол танай ах дүү нар чинь

-тэр муу шуналтай хүүхнээс л боллоо гээд Сүйд майд болох байлгүй дээ. Сайн л бодоорой. Үүнээс гурав хоногийн дараа яг үд дундын хирд Заяат нэг хэсэг том шороог ухаж байтал гэнэт газар нүргэлж бөөн шороо нураад гурван метр хол ухаж байсан хонгилд Заяат дарагдах нь тэр. Гэнэт хүн муухай хашгирах чимээнээр ойр хавьд нь байсан хүмүүс цуглахад Заяатын ухаж байсан хонгилд нуралт болж тэр чигээрээ цөмөрчээ. Ганиймаа орилон хашгиран манай нөхөр дарагдчихлаа. Таминээ туслаач гэж хичнээн ориловч тэр хэдэн метрийн цаанах хонгилд дарагдсан Заяатын тэр хавиас юу ч сонсдохгүй болж хүмүүс ч аврах ангийнхныг дуудан авчирсан боловч газар гавихгүй бүтэн долоон цаг ухаад арай чуу хөл нь цухуйж байх аж.

Дахин хэдэн цаг ухаж байж түүнийг гаргасан боловч аль хэдийн амьсгаа хураажээ. Хүмүүс бөөгнөрөн Ганиймааг аргадаж Заяатын цогцсыг тургэнийхэн ирж үзэхэд хоёр цагийн өмнө амьсгал хураажээ гэсэн актыг тогтоов. Ганиймаа шууд хот руу ах дүү төрөл садан руугаа утасдаж, Заяатын ганц хөгшин эгчид хүртэл хэл дуулгажээ. Орой нь хүмүүс ирж. Батаагийнхан Ганиймаад хань болж байв.

Энэ аймшигт үйл явдал уурхайн даргын чихэнд хүрч, тэр тушаал гаргаад байхад яагаад ийм явдал болдог билээ гэж сэргийлэхийг дуудсан боловч, бид уг газрыг хүмүүст хэлж хэд хоногийн өмнө ухахыг зогсоосон. Харин тэд өөрснөө ухсаар байсан юм билээ гэж мэдэгдэв. Маргааш өглөө нь Батаагийн авгай ирж Ганиймаа одоо ингээд уурхайн дарга ирж газар дээр нь үзэх гэнэ. Чи очилгүй болохгүй дээ. Биеэ бариад бүх болсон явдлыг хэлээрэй.

Оршуулахад чинь тус болох юуны магад. Урьд өмнө хүмүүс нас барахад уурхайнхан нэг их ирээд байдаггүй л дээ. Гэхдээ энэ шинэ дарга л ирэх юм гэнэ гэв.

Ганиймаа санд мэнд хувцсаа солиод нөгөө газар руу Батаагийн авгай болон хэдэн авгай хүүхнүүдийн хамт явж очив. Өчигдрийн ундуй сундуй ухсан газрын ам онгойж энд хар үхэл гэсэн мэт сэтгэл сэрдхийлгэнэ. Албаны боллоотой хэдэн машин ирж зогсов. Хамгийн түрүүчийн машинаас цэнхэр костюмтай намхан нуруутай ганган эр бууж ирэхэд дарга ирлээ, дарга ирлээ гэлцэнэ. Ганиймаач яах ч учраа олохгүй амьтан дэмий л нулимсаа сэмхэн арчин зогсож байв. Тэр дарга алив гэр бүлийн хүн нь ирсэн үү? гэхэд хүмүүс ирсэн ирсэн энд байна гэгцгээв. Ганиймаа даргын өөдөөс эгцрэн харах гэтэл юу вэ? өөрийнх нь нөхөр Цэнгэл харагдав. Цэнгэл ч Ганиймааг харангуутаа зогтусаж, Ганиймаа ч хойшоо ухрав. Хүмүүс мэл гайхаж нэг хэсэгтээ хэн ч дуугарсангүй зогсоцгоов. Цэнгэл ам нээж -Ээ харлаа энэ чинь танай нөхөр байсан юм уу? Тун тоогүй юм болж дээ. Хотоос хүмүүс ирсэн үү? Тэгээд хэзээ хөдөөлүүлэх гэж байна гэж асуухад, Ганиймаа эхэр татан уйлж, муужран унав.... хэсэг хугацааны дараа Ганиймаа сэргэн, эргэн тойрныг харахад Цэнгэл өмнө нь зовсон байртай зогсож байв. Ганиймаа арай ядан ам нээж чи энд ирсэн юм уу? гэж сөөнгөтсөн хоолойгоор асуув. Цэнгэл тийм ээ. Би ажил аваад удаагүй байна, хүүхдүүд сайн уу? гэж асуухад Цэнгэл уртаар санаа алдаж сайн, сайн гээд -за би чамайг гэрт чинь хүргэж өгье тэгээд тухтай ярилцая гээд машин тийш явцгаав. Цэнгэлийн машины ард суусан Ганиймаа үг сүтгүй уйлж, гар хуруу нь чичрэн нулимсаа арай ядан арчина. Төдөлгүй гэрийн гадаа нь ирэн ороход хүмүүс угтан авч даргаа тийшээ гэж суудалд залав.

Ганиймаа даанч ийм юм болно гэж санасангүй. Миний л муу заяа байх даа. Нөгөөдөр л гаргая гэж тохирсон доо гэж арай ядан хэллээ. Цэнгэл түүнийг их өрөвдсөн харцаар харж, тун тоогүй юм боллоо. Уул нь би энэ хавийн газар дээр ажиллахыг хориглосон тогтоол гаргаж зохицуулсан юмсан. Даанч өөрсдөө үгэнд оролгүй байсаар ийм боллоо. Одоо яая гэхэв дээ. Ганиймаа минь чи оршуулгын тал дээр зовох юмгүй. Бух зүйлийг нь бид бэлдэж өгнөө. Юу хэрэгтэйгээ манай хүмүүст хэлээд явуулаарай. Би одоо явалгүй болохгүй нь төвөөс хүмүүс ирчихээд хүлээж байгаа. Ажил явдлын дараа тухтай уулзая гээд гарав. Цэнгэл тэр шөнөдөө хот руу машин явуулж маш гоё хүрэн өнгөтэй алтадсан бариул сэнжтэй сайхан хайрцаг ороох торго дурдан, бүх л зүйлийг жин тан болгож өглөө гэрт нь хүргүүлэв... Ганиймаа шөнөжин нойргүй уйлж, элдвийг бодон би Цэнгэлийг хаяж яаж бардамнаж явлаа даа тэгэхэд Цэнгэл надад ингэж тусалж байх ч гэж. Бид хоёр ийм аймшигт үед уулзах ч гэж хорвоо санаснаар болдоггүй нь үнэн л юм байна. Өст хүн өлийн даваан дээр гэгчээр яг Цэнгэлийг ажил авсан дор миний нөхөр үхэж байдаг. Яасан заяагүй хувь тавилан гэж байдаг байнаа гээд л ганцаараа уйлж элдвийг бодон шөнийг арайхийн барав. Тэгээд маргааш нь оршуулга болж уурхайн зүгээс бүхнийг хийж их л өргөн хүндэтгэлтэйгээр Заяатыг оршуулжээ... Ганиймаа нөхрөө оршуулж ирээд ерөөсөө л түргэн шиг л үхэх хэрэгтэй юм байна. Над шиг ийм азгүй хүн энэ орчлонд амьд явахын хэрэггүй юм байна. Би чухам юу бодож байлаа даа. Бүх зүйлийг сайн сайхнаар бодож Заяатыг олсныгоо мөнхийн юм шиг санаж байсан. Хорвоо гэдэг үнэхээр л санаснаар болдоггүй юм байна. Одоо би үхэхээс өөр ямар ч замгүй болжээ. Олон жил хоёр хүүхдийнхээ царайг хараагүй. Тэр хоёр одоо бараг намайг танихгүй шахам болоо биз дээ. Таньдаг юмаа гэхэд хаяад явчихсан эхийг хэн ээж гэж бодох юм. Гэх мэт элдвийг бодож багтарч үхэх дөхөж байв. Маргааш нь хотоос ирсэн улсууд буцаж Ганиймаа ганцаараа гиюүрэн эргүү хурга шиг болчихсон юм сууж байтал гэнэт хаалга цохин хүн орж ирэв.

Харсан чинь Цэнгэл байв. Ажил явдал яаж өнгөрөв дөө гэхэд Ганиймаа сайхан болж өнгөрлөө. Чиний ач буянгаар дутсан юм байхгүй. Бүх юм сайхан боллоо. Би чамд их баярласан шүү гэж арай ядан хэлээд учир зүггүй уйлав. Цэнгэл

Ганиймааг аргадан өрөвч зөөлөн сэтгэлээр нулимсыг нь арчиж, биеэ барь, амьдрал хатуудаа хатуу шүү дээ.

Одоо яая гэхэв, дэндүү харамсалтай л юм боллоо. Би чамайг энд гэж яаж мэдэх вэ дээ, чи чинь усанд хаясан чулуу шиг л алга болчихсон юм чинь. Нөхөртэй суусан гэж л дуулснаас, хаана гэдгийг чинь ямар мэдсэн биш дээ. За одоо жаахан тайтгар хоёулаа ярих юм байна. Чи жаахан биеэ барь. Санаснаар болдоггүй орчлонд хүн сайн муу ихийг л үзнэ шүү дээ. Чи жаахан тайвшир гээд Ганиймаад цай аягалан өгч зэрэгцэн суув. Ганиймаа:

-Би ч ёстой заяагүй амьтан хань ижлээ, хоёр сайхан хүүхдээ орхин, орхин энэ хүнийг дагаж эцэст нь ийм аймшигтай юм үзэж байх ч гэж, ёстой амьд явахын хэрэг алга. Бушуухан үхэхээс гээд мэгшин уйлна. Цэнгэл юу гэсэн үг вэ? Үхнэ гэдэг шнь тийм сайхан юм уу? Чи чинь үр хүүхдээ бодох хэрэгтэй шүү, бид хоёр амьдрахгүй ч гэсэн хүүхдүүд чинь байна. Чамаас би нуух юу байх вэ? Чамайг ирэх болов уу? гэж хүлээгээд ирэхгүй болохоор чинь нэг хүүхэн авсан. Түүний нөхөр нь нас барчихсан юм. Нэг хүүхэдтэй тэгээд яахав зовлон үзсэн хүн болохоороо надтай амьдарч намайг ойлгоод дажгүй байна. Манай хоёр ч түүнд муугүй. Ээж гээд харайлгаад байгаа. Яахав амьдрал болох өдрөө болж л байдаг, болохгүй цагтаа болохгүй

л байдаг. Нэгэнт хорвоо иймээс хойш яая гэхэв. Чи харин үхэх тухай элдвийг бодож болохгүй. Хойшид яаж амьдрахаа л сайн бод. Би чамд мөнгө төгрөгөөр туслана шүү дээ. Чи хотод байртай бол тэндээ очоод амьдар. Би чамд сая төгрөг өгье, чи түүгээр эргүүлж тойруулаад юм хий. Эсвэл эндээ байх юм уу? өөрөө л мэд гэж шуудхан хэлэв. Ганиймаа би энд юугаа хийж байх юм бэ? Энэ муу байрыг нь зарчихаад л хотыхоо байранд очно. Тэгээд харин яаж шүү амьдардаг юм байгаа юм. бүү мэд үхмээр л санагдаад байх юм.

-Юу гэсэн үг вэ? Тэгж ярихгүй шүү. Амьдрахын төлөө л явдаг биз дээ. Тэр тусмаа чи сайн сайхан амьдрахыг хүсдэг шүү дээ. Хоёр сайхан хүүхэд байна. Нэгийг нь авчраад хамт байсан ч болно шүү дээ. Би чамд ер нь буруу өгөхгүй ээ. Үнэндээ бас миний урагшгүйгээс их болсон шүү дээ. Би хожим л ухаарсан. Над шиг урагшгүй хүн гэж хаана байх вэ? Тухайн үедээ чиний зөв байсан байх. Би чамд муу санадаггүй ээ. Өөрөө урагшгүйтчихээд чамд буруу тохох нь утгагүй шүүдээ. Чи сайхан л амьдрая гэж зүтгэсэн хүн. Юу нь буруу байх вэ. Талийгаач тийм ч муу хүн биш юм билээ. Хөөрхий амьдрахын төлөө л зүтгэж яваад амь насаа алдчихлаа. Нэгэнт өнгөрсөн юм болохоор одоо чи сэтгэлээ барьж цаашид яаж амьдрахаа л бод. Юу л хэрэгтэй бол би чамд туслана. Хоёр сайхан үрээ бодоход би чамайг гэхгүй яах юм бэ? Хоёулаа нэг нүүр хагарсных сайн ярьж байгаад шийдье.

Чи энэ байраа зарах юм бол би уурхайдаа авчихая. Чамд мөнгийг нь шууд өгнө. Тэгээд хоёр айл оруулчихая. Хот руу юм зөөхөд чинь би унаа гаргаад, ачих хүн олоод өгнө. Чи бүү санаа зов. Ийм л үед чинь чамд би туслахгүй юм бол хэзээ туслах юм. Би ч бас урагшгүй ч гэсэн эр хүн шүү дээ.

Тэр хоёр ийн ярилцсаар дараагийн долоо хоногт хот руу Ганиймаа нүүх бопжээ. Ганиймаа сансрын хоёр өрөө байранд садангийнхаа нэг авгайг авчирч хоёулаа байж байтал нэг өдөр утас дуугарч Цэнгэл

- бид 3 очлоо. Чи байж байгаарай гэх нь тэр. Ганиймаа удаан хараагүй хоёр хүүхдээ ирэх болсонд учир зүггүй баярлаж бас сэтгэл нь тавгүйцэн уйлна. Хаалганы хонх дуугартал очиж онгойлговол өөрөөс нь өндөр болсон охин хүү хоёр нь танигдахын аргагүй том болчихсон харагдав. Тэр хоёр хүүхдээ тэврэн уйлж гарахад, Цэнгэл

-За Ганиймаа биеэ барь, тайван бай гээд дотогш оруулав.

Удахгүй цай хоол бэлэн болж тэд ширээ тойрон сууж Ганиймаа хоёр хүүхдээ ээлжлэн үнсэж ээжийгээ уучлаарай гэж дахин дахин хэлж уйлна.

Бид тань дээр ирж байнаа. Та тайван бай. Аав бид хэдуулээ таныг эргэж байх болно гэж хүү нь их л том хүн шиг хэлэв. Ээжийгээ уучлаарай гээд Ганиймаа дахин эхэр татан уйлахад, за таныг бид уучлахгүй гээд яах юм бэ? Нэгэнт болоод өнгөрсөн юмны хойноос олон юм бодоод яах гэсэн юм. Та одоо эрүүл мэндээ бодох хэрэгтэй. Ямар ч байсан бид таны төлөө л байж таараа. Та ганцаараа байвал би ирээд тантай хамт байсан ч болно шүү дээ. Ээж минь юмыг уужуу бодох хэрэгтэй гэдэг биз дээ гээд хээв нэг чад хийсэн үг хэлэхэд, үгүй энэ хүүхдүүд чинь ямар сүрхий юм ярьж байна вэ? Хүний үр гэдэг ийм айхтар байдаг байна шүү дээ. Орхиод явчихсан ээжийгээ харж үзнэ гээд сууж байдаг. Ай миний тэнэг толгой тэгэхэд юу бодож явлаа даа. Ийм ч юм байх гэж. Ганиймаа дотроо гаслан бодож суув.



## Цэнгэл

-за бид 3 ингээд явъя даа. Энд гэрийн утас, ажлын утас бий. Санаа зовохын хэрэггүй. Бид ч чам руу ярьж байх болно гээд нэрийн хуудсаа өгч тэд явахаар бослоо. Ганиймаа хоёр хүүхдээ үнсээд миний хоёр хүү ээж дээрээ ирж байгаарай гээд нулимс цийлсэн нүдээр тэднийг харж их л өрөвдөлтэй хоцров. Цэнгэл хоёр хүүтэйгээ машинд сууж гэрийн зүг явах зуур

-Ээж нь ер нь жаахан ядрах байх. Сэтгэл санааны хувьд ч, хүнийхээ хувьд ч буруудсан болохоор ямар л олигтой байв гэж. Миний хоёр хүү ээлжлэн ээжийгээ эргэж ирж сэтгэл санаагий нь засах хэрэгтэй. Аав нь маргааш хөдөө уурхай руугаа явчихна. Та хоёр л ээжийгээ харж хандаж байгаарай. Аав нь ээжид чинь нэг ломбард байгуулж өгнө. Дараагийн долоо хоногоос ирээд л больё. Одоо та хоёр ухаан сууж том болж байна. Ээждээ тус болох хэрэгтэй гэхэд охин нь

-Ээж бид нарыг үнсэнд хаясан шалз шиг орхиод явсан гээд байдаг шүү дээ. Одоо бид хоёрыг хүүхдээ гээд хайрлах юмуу даа гэж их л нухацтай өгүүлэв. Цэнгэл

-За яахав. Тэр үедээ орхиод явсан байж болно л доо. Харин одоо бол ээжид чинь та хоёроос өөр хэн ч байхгүй шүү дээ. Өөрөөс гарсан хоёр хүүхдээ түшихгүй юм бол тэр өөр хэнийг гэх билээ дээ. Та хоёр үүнийг сайн ойлгох хэрэгтэй. Аав нь ч гэсэн тухайн үедээ ээжид чинь гомдож л байсан. Гэхдээ одоо бол харин ээжийг чинь их өрөвдөж байна. Бүсгүй хүний богино ухаанаасаа болоод алдсан хүн. Их л сайн сайхан амьдралтай болно гэж итгэж байсан хэрэг. Харин хорвоо түүний бодсоноор болгосонгүй. Буруу үйлийг буцааж эзнийг нь шийтгэчихлээ. Тэгэхээр яалтай ч билээ. Бид л энэ хүнийг харж хандаж зовлон гунигийг нь хуваалцах хэрэгтэй. Та хоёр ээждээ сайхан сэтгэлээр хандаж байх хэрэгтэй. Ээж гэдэг хүнд ганцхан л олддог юм. Харин та нар эх хүний ачийг хариулах их өртэй шүү үүнийг бодож явцгаа. Охин нь тухайн үедээ ээж биднийг бодоогүй л явчихсан шүү дээ. Цэнгэл тэр нь яах вэ? Муу үйлийн эсрэг сайхан сэтгэлээр хандаж явбал сайн сэтгэлийн үр эзэндээ заавал сайнаар тусдаг юм. Миний хоёр хүү үүнийг санаж яв. Аав нь та хоёрыг юугаар ч дутаахгүй. Харин та хоёр сайн хүн болж сайн үйл бүтээж явахыг л хичээх учиртай. Ойлгов уу?

-За гэж хоёр хүүхэд зэрэг хэлэхэд машин гэрийнхээ гадаа ирж зогслоо...

Ганиймаа тэр гурвыг явсныг дараа -их л юм бодлоо. Хөөрхий муу хоёр хүүхэд минь ээжийгээ бэтгэртэл л санасан байх. Би гэдэг тэнэг толгой ер нь юу хийж явлаа даа. Ай халаг

-Цэнгэл гэдэг хүнийг би өнөө хүртэл ойлгоогүй л явж... Үнэхээр сайн хүн гэдгийг нь сая л мэдлээ дээ. Хоёр хүүхдийг минь аль хэдийнэ миний эсрэг болгочихсон байх гэж хүртэл бодож явлаа. Тэгэхэд хөөрхий ээжийгээ харж ханд гээд л надад ломбард хүртэл байгуулж өгнө гэнэ шүү. Намайг амьдраг, амьд яваг гэж тэр хүн ингэж байхад би юу гэж үхнэ гэж солиорч байв даа. Нээрэн ч хоёр амьдрах нас аргагүй. Үртэй хүн үхэж болдоггүй гэж үнэн л юм байна даа. Би амьдарнаа. Одоо хоёр хүүгийнхээ төлөө тэгвэл амьдрахад юу нь болохгүй байх вэ? Ломбардандаа нөгөө муу Сарантуяаг авч ажиллуулья. Олон жил нябо хийсэн хүн. Дэндүү шударга сайхан хүн байгаа юм. Хөөрхий саяхан орон тоогоор халагдсан гэсэн. Хэдэн төгрөг өгөөд л ажиллуулчихъя. Үхсэний хойноос үхэлтэй нь биш дээ. Уул нь Заяат амьд байсан бол бид хоёр гайгүй л амьдрах байсан байх. Хүний шунал гэдэг дэндүү аймшигтай.

Намайг хүн аваад ажиллуулъя гэхэд ажиллуулчихсан бол юунд ийм аюулд унах билээ. Өдийд амьд л байх байсан шүү дээ. Ёстой л “Алтанд дарагдсан амь” л гэж энийг хэлдэг байхдаа. Би ч ер нь азгүй л хүн юм даа.

Ингэж муугаа үзэж явах гэж дээ. Дэндүү ихийг бодож байж ийм боллоо шүү дээ.

-За одоо яая гэх вэ? муу Заяатын хойноос хэдэн ном ерөөл уншуулахаас даа. Нэгэнт өнгөрсөн хүнийг бодоод ч яахав. Ямар босоод ирэх юм биш. Харин хойноос нь буян үйлдэх нь л зөв байх гээд хэдэн төгрөг өвөртлөн хийдийн зүг рүүруу царайлан алхлав.....

Өдөр хоног өнгөрсөөр нэг сар боллоо. Ганиймаад Цэнгэл тохилог сайхан байртай ломбардын газар нээж өгснөөс тэр сэтгэл нь сэргэж өдөртөө сатааран, хааяа уртаар санаа алдахаас өөр нэг их зовлонгүй л байх болов.

Нэгэн бүтэн сайн өдөр хүү нь ирж

- Ээж цөмөөрөө салхинд гаръя... аав таныг аваад ир гэж байна, гэсээр орж ирэв. Ганиймаа би салхинд гараад ч яах юм билээ. Ямар юмаа хийж явах билээ гэж дотроо бодоод

-Ээж нь тийшээ яваад яах юм бэ? Та нар л зугаалаад ир гэхэд, хүү нь үгүй ээ аав таныг аваад ир гэсэн юм чинь, гадаа машин хүлээж байгаа. За та хувцас гэж шавдуулав. Ганиймаа би яаж очих вэ? Аягүй бол нөгөө авгай нь бас очвол эвгүй юм болно. Тэр нь юу ч гэж бодох юм билээ. Миний байж байгаа царай яанаа гэх аятай юм бодсоор арга буюу хүүгийнхээ шаардлагаар хувцсаа өмсөөд гарлаа. Шинэхэн жип машины ард суугаад Цэнгэлийн гадаа очиж зогсов бололтой. Ганиймаа бүр санаа зовж, хэн гарч ирэх бол гэж айх гайхах зэрэгцэн гадсан дээр суусан юм шиг өндөлзөн суув.

Тэгтэл охин нь хөөрхөн хүү хөтөлсөөр гарч ирлээ. Дараа нь ганган хувцасласан цэл залуухан гоо сайхан бүсгүй суналзтал алхан гарч ирснээ эргэн харж Цэнгэлээ тургэлээч гэх дуу сонсдов. Ганиймаагийн дотор нэгэн үе харанхуйлж, -Би голоод хаяж байхад Цэнгэлийг ийм сайхан хүүхэн тоогоод л сууж байдаг хачин чиг хорвоо юм даа. “Ёстой голсон юм гол дээр, шилсэн юм шил дээр” гэгч л болсон байна шүү дээ. За яахав хувь тавилан гэдэг ийм л байж. “Эрийг бүү бас, далайг бүү янд” гэдэг л энэ байхдаа.

Яасан ч сайхан царайтай юм. Ямар ч гоё биетэй юм гэж дотроо бодон өөрөөсөө ичих шиг болж их л бэргэж суулаа. Цэнгэл цаанаас нь инээмсэглэн гарч ирээд машины хаалга нээн Нараа энэ манай Ганиймаа та хоёр танилц гэхэд Наран жигд цагаан шүдээр яралзтал инээмсэглэн Наран гэж гараа сунгав. Ганиймаа арай чуу гараа өгч Ганиймаа гэж сулхан дуугарах аядав. Хөөрхөн хүү Цэнгэлийн өвөр дээр суун эрхлэн Ганиймаа, хоёр хүүхэд цөм машинд сууцгаав. Удалгүй тэдний зуслангийн гадаа ирж зогсов. Цэнгэл Ганиймааг

-За энэ манай зуслан. Агаар нь их сайхаан. Чи ядарсан биз дээ. Жаахан энэ сайхан агаарт амар. Би яахав нэг хүнтэй амьдралаа холбосон. Хөөрхий нөхөр нь хүнд алуулчихсан юм гэнэ лээ. Энэ хүү нь бүр жаахан юм ирсэн одоо гайгүй том болж л байна. Бид хоёр яахав, хоёр зовсон амьтан бие биеэ олжзовлон жаргалаа ярьж танилцаад л амьдрахаар болсон нь энэ дээ. Чамаас юугий нь нуух вэ? Харин бурханы авралаар энэ хоёр хүүхэд дүүдээ аягүй

хайртай, Нараа ч миний хоёр хүүг ёстой эхийн сэтгэлээр хайрладаг. Бид ингээд дэм дэмэндээ болоод л байна. Харин одоо чи л биеэ бариад жаахан хөл дээрээ босохыг бод. Одоо бас нас яагаа ч үгүй байна. Чамд амьдрал байна шүү дээ. Болохгүй бүтэхгүй юмаа надад хэлж бай. Манай Нараа ухаантай сайн хүүхэн шүү.

Чамайг сайн ойлгоноо. Үнэнийг хэлэхэд тэр чамаас дутуугүй зовсон хүн шүү дээ гэж их л өөриймсөг маягаар ярив. Нараа энэ завсар бэлтгэж ирсэн зуушаа ширээн дээр дэлгэж, цахилгаан зуухан дээр цай тавьж чаналаа. Хүүхдүүд нь гадуур бөмбөг хөөн гүйлдэж, жаахан дүүгээрээ тоглон инээлдэнэ. Ганиймаа үг дуугүй Цэнгэлийн үгийг сонсож байснаа

-Одоо яахав дээ. Амьдрал нэгэнт ийм болсноос хойш, би чамд их л баярлаж байна. Чи надад маш их тус боллоо. Хамгийн гол нь чи миний хоёр хүүхдийг надаас холдуулаагүй байгаа нь намайг их баярлуулж байна. Би яахав ингээд л амьдралын аясыг хараад л гэлдэрч явахаас даа. Өөр яах ч билээ дээ. Сайн авгайтай таарсан л бол болоо доо. Чамд халамжтай, хоёр хүүхдэд минь сайн л байвал болох нь тэр дээ. Би яахав хувь тавилангаараа л болж. Энэ ломбардаа сайн ажиллуулаад байвал ч амьжиргаатай л юм шиг байна. Цаашдаа юу болохыг хэн мэднэ. Чи надад санаа зовохын хэрэггүй. Харин ажлаа л сайн хийхийг бод. Хорвоо намайг шийтгэснээр ингэсгээд нэг юм дуусах байлгүй дээ, гэж үгээ зөөн хэлэв. Тэгтэл Нараа

-За цайгаа ууцгаая гээд дуудав. Цөм л байшин руу орцгоов. Энд суу гээд сайхан зассан ширээний ар луу Ганиймааг зааж, хүүхдүүдээ мөн л суулгав.

Халаах төхөөрөмжинд хийсэн зуушууд, гахайн шарсан мах, гуляшь зэрэг төрөл төрлийн хоол бэлэн болж бүгд цайлж эхлэх зуур, Цэнгэл нэг том шилтэй Чингис архи гаргаж ирэн хундагалж,

-За ингээд эрүүл энх ажлын амжилтын төлөө гээд гурвуулаа тулгачихая, бас та нарын танилцсаны төлөө гэж нэмж хэлэв. Нараа инээмсэглэн Ганиймаа руу анхаарлаа хандуулж сайхан танилцсаны төлөө ууцгаая гээд эхний хундаганаас амсаад тавив.

Ганиймаа дотроо элдвийг бодож гансарч суувч арга буюу хундагыг өргөн уув. Цайлсаны дараа хүүхдүүд нь

-Ааваа агаарын теннис тоглоё гэж дуудав. Тэднийг гарсны дараа Наран Ганиймаа хоёр үлдэж, Наран аяархан дуугаар за яахав дээ амьдрал ямар хүний санаснаар болох биш дээ. Бид ийм л учир тавилантай юм байлгүй дээ. Би ч бас өөрөөс чинь дутуугүй зовсон хүн сайхан залуутай амьдралаа холбоод айл шиг л сайхан амьдарч байлаа. Гэтэл тэр маань Солонгос явж ажил хийнэ гээд болдоггүй. Яахав амьдрал юм болсон хойно тэгээд л яваад өгсөн. Хоёр дахь жилдээ харин амь үрэгдсэн гэж мэдээ ирж би энэ бяцхан амьтантай үлдсэн. Ээж аав маань нас барсан, би өнчин хүн л дээ. Тэгээд ганц муу эгч дээрээ л хүн болсон. Ингээд л би хайртай хүнээсээ хагацаж хоцорсон юм даа гээд хоёр хацрыг нь даган нулимс урсахад Ганиймаа ч даган уйлж, зовлон гэдэг хэлж ирэх биш дээ, би ч яахав өөртөө л гомдохоос өөр зүйлгүй болсон хүн. Эднийгээ хаяад их жаргах юм бодоод л мангуурч л явлаа. Тэгээд орчлонгийн их хүрдэнд дутуу ухаантай бүсгүй хүн зовдог юм байна гэдгийг зүрхээрээ мэдэрлээ. Буруу санааныхаа хариуг хорвоогоос амсаж хар гуниг тээж хоцорсон би үхэхсэн гэж л бодож байлаа. Тэгтэл Цэнгэл ухаантай хүн болохоороо намайг хоёр хүүхдээ бодоод амьд

яваач гэдэг байна шүү дээ. Нээрэн ч бодоод байхад би чинь хоёр сайхан үртэй эх хүн шүү дээ гэсэн бодол төрж энэ хоёрыгоо харж явья даа гээд өнөөдөр би амьдын төдий амьтан хүүдээ хөтлөгдөөд гарч ирлээ шүү дээ. Би та хоёрт их баярлаж байна. Чи миний хоёр хүүхдэд эх болж өдий зэрэгтэй авч явсанд чинь би баярлалгүй яахав. Чиний сайхан сэтгэлд би харин баярлахын ихээр баярлаж байна. Намайг ингэж ойлгож байгаад чинь ч би баярлаж байна.

Сайхан сэтгэл гэдэг сайхан л юм байна, мэгшин уйлах нь аргаа барсан хүний л жинхэнэ төрх ажгуу. Энэ уулзалтаас хойш Наран, Ганиймаа хоёр эгч дүү шиг сэтгэлийн үгээ ярьж, бүсгүй хүнийхээ хувьд хоёр биенийхээ зовлон жаргалыг ярилцаж хэдэн хүүхдийнхээ төлөө амьд явахын гэрэл гэгээг харсан гэхэд болохуйц дотно байх болжээ.

Цаг хугацаа өнгөрөх бүр хоёр хүүхэд нь томорч хүү нь дээд сургууль төгсөж гадаадад сургуульд явах болж, охин нь нэг сөөвгөр залуу дагуулан гүйж хайр зарлах нь бас нэгийг өгүүлэх аж... Заяа тавилангийн эрхээр ганцаар хоцорсон Ганиймаа нөхөрт гарах ч гэж бодолгүй хэдэн жилийн нуур үзэж нөгөө ломбардандаа суусаар өдөр хоногийг элээж, өөрөө өөрийнхөө бүрэн бүтэн амьдралыг бусниулсан хүн өнөөдөр ингэж л ганцаардан зовлон амсаж суух учиртай юм байлгүй дээ гэж гунигийн нулимсаа дотогшоо залгин гутарлын дарс нэрэх боловч цагийн зүү довтолсоор үсэнд нь цагаан хяруу аль хэдийн буужээ.

Ганиймаа нэг орой гэртээ ганцаар гиюүрэн сууж элдвийг бодон Цэнгэлийг эргэн санаж,

-Хүн гэдэг сонин юм. Цэнгэл надтай байхдаа ийм хүн байгаагүй дээ. Харин энэ Нарантай суугаад л бүр хийморь нь сэргэж “Эр хүн шиг эрвэлзэж, Эмээлтэй морь шиг дэрвэлзэж” явах болжээ. Мөн хачин юм даа.

-Би Цэнгэлийг ийм болно гэж зүүдлээч үгүй явлаа. Хүн чинь нууц юм их байдаг юм байна гэж дотроо бодон хөөрхий Заяатыг би ийм амархан орчлонгоос хальчих юм гэж даанч бодолгүй явлаа.

Алт гэдэг аминд хүрдэг гэж хууччуулын ярьдаг нь аргагүй үнэн байсан даа. Дэндүү их олз олох гэж зүтгэсээр байгаад л Заяат амиа алдсан. Тэр алт авах гэж газар ухаагүйсэн бол өдийд амьд л явах байсан. Түүний богинохон амьдрал нь “АЛТАНД ДАРАГДСАН АМЬ” гээч л болсон доо.

Үнэхээр санаснаар болдоггүй хорвоо юм билээ дээ гээд зүрх шимшруулэн бодсоор ганцаардлын мананд төөрсөн гунигийн харанхуйд сэтгэл чилээн суух нь өөрийнхөө алдаанд өөрөө багалзуурдуулсан гайт үйлийн гэмшил гэлтэй. Түүний царай зус арай ядан хөдлөх сүүдэр нь хүртэл хоосон мэт үзэгдэх ажгуу...

# Table of Contents

[Өмнөх үг](#)  
[Алтанд дарагдсан амь](#)